МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

НОТЛОХ БАРИМТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны төрөл:	**Харьцуулсан судалгаа**
Судалгааны код:	**СТ-25/245**
Хугацаа:	**2025.10.22**
Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин
Хянасан:	ПСХХ–ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ
Судлаач:	ПСХХ–ийн Судалгааны хэлтсийн ахлах референт О.Нарантуяа

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 2
УДИРТГАЛ 3
НЭГ. НОТЛОХ БАРИМТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ 4
1.1.Австралийн Холбооны Улс 5
1.2.Америкийн Нэгдсэн Улс 5
1.3.Бүгд Найрамдах Солонгос Улс 6
1.4.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 7
1.5.Канад Улс 7
1.6.Оросын Холбооны Улс 8
1.7.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 8
ХОЁР. НОТЛОХ БАРИМТЫН ТӨРӨЛ 9
2.1.Бие даасан хууль, дүрмээр зохицуулдаг улс орнууд 9
2.1.1.Австралийн Холбооны Улс 9
2.1.2.Америкийн Нэгдсэн Улс 10
2.1.3.Канад Улс 12
2.2.Эрүүгийн болон иргэний процессын хуулиар зохицуулдаг улс орнууд 14
2.2.1.Бүгд Найрамдах Солонгос Улс 14
2.2.2.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 16
2.2.3.Оросын Холбооны Улс 18
2.2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 22
ГУРАВ. НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ ЖУРАМ 27
3.1.Австралийн Холбооны Улс 27
3.2.Америкийн Нэгдсэн Улс 27
3.3.Бүгд Найрамдах Солонгос Улс 27
3.4.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 27
3.5.Канад Улс 28
3.6.Оросын Холбооны Улс 28
3.7.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 29
ДӨРӨВ. НОТЛОХ БАРИМТЫН ЗӨВШӨӨРӨГДӨХ НӨХЦӨЛ 31
4.1.Австралийн Холбооны Улс 31
4.2.Америкийн Нэгдсэн Улс 32
4.3.Бүгд Найрамдах Солонгос Улс 33
4.4.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс 34
4.5.Канад Улс 35
4.6.Оросын Холбооны Улс 36
4.7.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс 37
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 39
НОМ ЗҮЙ 43

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

УДИРТГАЛ

“Нотлох баримтын эрх зүйн зохицуулалтын талаарх гадаадын зарим улсын харьцуулсан судалгаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн (ПСХХ)-д гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь нотлох баримтын эрх зүйн орчин, зохицуулах зүйл, нотлох баримтын төрөл, зөвшөөрөгдөх нөхцөл болон нотлох баримт цуглуулах журмыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ:

Энэхүү харьцуулсан судалгаанд захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Австралийн Холбооны Улс, Канад Улс, Америкийн Нэгдсэн Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Оросын Холбооны Улсын туршлагыг сонгон судалсан.

Судалгааны арга зүй:

Судалгаанд сонгож авсан улсуудын холбогдох хууль тогтоомжийг харьцуулан судлах үүднээс харьцуулсан шинжилгээний арга зүй, хууль зүйн баримт бичгийн судалгааны арга ашигласан болно.

Судалгааны ажлын бүтэц:

Энэхүү судалгаа нь удиртгал, нэгдүгээр хэсэг нотлох баримтын эрх зүйн орчин, зохицуулах зүйл, нотлох баримтын төрөл, хоёрдугаар хэсэгт нотлох баримтын төрөл, гуравдугаар хэсэгт нотлох баримтын зөвшөөрөгдөх байдал, дөрөвдүгээр хэсэгт нотлох баримт цуглуулах журмын талаар судалсан болно.

Түлхүүр үг:

Монгол: нотлох баримт, нотлох үүрэг, нотлох баримтын шалгуур, төрөл, хууль бус нотлох баримт.

Англи: Evidence, burden of proof, admissibility of evidence, privileges, exclusionary rule.

НЭГ. НОТЛОХ БАРИМТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ЗОХИЦУУЛАХ ЗҮЙЛ

Нотлох ажиллагаа нь баримтлах зарчим, шүүгч болон бусад оролцогчдын эрх зүйн байдал, шүүн таслах ажиллагааны онцлогоос хамааран ялгаатай байдаг. Хууль зүйн уламжлалаар Англи-Саксоны эрх зүйн тогтолцоонд хэрэглэгдэж байсан ***яллах***, Ром-Германы эрх зүйн тогтолцоонд хэрэглэгдэж байсан ***эрэн сурвалжлах*** гэсэн хоёр загвар байсан бол орчин үед эдгээрийн онцлог шинжүүдийг хадгалсан холимог загварыг улс орнууд хууль тогтоомждоо тусгах нь түгээмэл байна (Б.Батзориг, Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, 2021, хууд. 30). Энэ гурван загварын онцлогыг авч үзье.

Иргэний нэхэмжлэлд үндэслэсэн, яллах загвар (the accusatorial model): Хувийн нэхэмжлэлд үндэслэсэн Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа бөгөөд хохирогч эрхээ хамгаалахын тулд хувийн журмаар эрүүгийн хэргийг мөрддөг онцлогтой (Б.Батзориг, Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, 2021, хууд. 30). Онцлог нь:

- нотлох баримт цуглуулж шүүхэд гаргаж өгөх үүргийг талууд хүлээнэ;
- шүүх идэвхгүй, төвийг сахигчийн байр суурьтай байна;
- нэхэмжлэгч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь шүүх хуралдааны явцад адил тэгш байр суурьтай байна;
- ээдрээ төвөгтэй хэргийг нотолж тогтооход эрүү шүүлт хэрэглэдэг. Яллахад тулгуурласан байцаан шийтгэх ажиллагаа нь “гомдол гаргахгүй бол шүүхгүй” мөн “хохирогч байхгүй бол шүүгч байхгүй” гэсэн зарчимтай. Өөрөөр хэлбэл хохирогч нь гомдол гаргахгүй бол эрүүгийн процесс эхлэхгүй.

Эрэн сурвалжлах загвар (the inquisitorial model): Мөрдөн шалгах байгууллага хохирогч гомдол гаргасан эсэхээс үл хамааран эрүүгийн хэргийг шалгадаг. Яллагдагч, шүүгдэгчийн эрх нь тодорхойгүй бөгөөд шүүгдэгчийн хэргээ хүлээсэн мэдүүлэг нь нотлох баримтын гол тулгуур гэж үздэг чиглэл юм (Б.Батзориг, Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, 2021, хууд. 31). Онцлог нь:

- мөрдөн байцаах, шүүн таслах үүргийг шүүх хариуцна;
- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг гэм буруутай гэж үзэж байцаах зарчмыг баримталж, эрүү шүүлт хэрэглэдэг;
- хуулиар тогтоосон журмаар нотлох ажиллагаа явагдана. Мөн нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох эсэх, нотлох баримтын нотлох чадвар ямар байхыг хуульд урьдчилан тогтоосон байна.

Энэ загварын гол онцлог нь албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд гэмт хэргийн талаарх гомдол, нэхэмжлэл гаргасан эсэхийг үл харгалзан санаачилгаараа хэрэг үүсгэн нотлох баримт цуглуулж, бэхжүүлдэг.

Холимог хэлбэрийн байцаан шийтгэх ажиллагааны загвар: Холимог загвар нь яллах болон эрэн сурвалжлах загварын онцлогуудыг багтаадаг. Энэхүү загварыг доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Уг хэв маяг нь нэг талаас, шүүн таслах ажиллагааг амаар, ил тод, нээлттэй байх, мэтгэлцэх байдлаар явуулах ардчилсан зарчмуудыг тусгасан. Нөгөө талаас, мөрдөн байцаалтын шатанд яллагдагч, түүний өмгөөлөгчийн эрхийг зарим талаар хязгаарладаг, хэрэг бүртгэгч, мөрдөгч хэргийг мөрдөн шалгахын зэрэгцээ хэргийн талаар тодорхой шийдвэр гаргадаг, хэргийн бодит үнэнийг тогтоох зарчмын хүрээнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид цагаатгах болон яллах, нотлох

баримтын аль алиныг нь цуглуулдаг хувилбар юм” гэж тодорхойлжээ (Б.Батзориг, Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, 2021, хууд. 41). Онцлог нь:

- нотлох үүргийг мөрдөгч хүлээдэг;
- мөрдөн байцаах, шүүн таслах чиг үүргийг өөр өөр субьектэд хариуцуулсан;
- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг урьдаас гэмт хэрэг үйлдсэн, гэм буруугүй гэж үзэж байцаан шийтгэх ажиллагаа явуулах зарчмыг (doctrine of the presumption of innocence) хэрэгжүүлнэ.

Холимог хэлбэрийн байцаан шийтгэх ажиллагааг шүүхээс өмнөх мөрдөн байцаах үе шат болон шүүх хуралдааны үе шат гэж хоёр хуваадаг. Мөрдөн шалгах байгууллага нь шүүхээс хараат бус байж, мөрдөн байцаах шатанд шийдвэрлэх асуудал нь шүүхээс хамааралгүй байдаг. Холимог загварын мөрдөн байцаалтын шатанд хохирогч гомдол гаргасан эсэхээс үл хамааран байцаан шийтгэх ажиллагаа явагдах боломжтой. Хохирогчийн гомдлоор үүсдэг хэрэг байдаг ч гэсэн мөрдөн шалгах байгууллага нь гэмт хэрэг үйлдэгдсэнийг олж мэдвэл гомдол гаргаагүй байсан ч эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтыг заавал явуулнаг (Б.Батзориг, Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, 2021, p. 32).

Дээрх загварууд нь эрх зүйн тогтолцоогоор ялгарч нотлох баримтын тусгайлсан хуультай (Австрали, Канад, АНУ), нотлох баримтыг эрүү болон иргэний процессын хуульд нэгтгэн зохицуулдаг (ИБУИНХУ, ХБНГУ, ОХУ), холимог шинжтэй хууль тогтоомжоор зохицуулдаг (БНСУ) онцлогтой байна. Дээрх загварын төлөөлөл болсон эдгээр улсын эрх зүйн зохицуулалтын талаар дэлгэрүүлэн авч үзье.

1.1.Австралийн Холбооны Улс

Австрали Улс нь нотлох баримтыг 1995 онд батлагдсан *Нотлох бариmтын тухай*[1] бие даасан хуулиар зохицуулдаг. Холбооны шүүхийн бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх (Part 1.2, §4) тус хууль нь таван бүлэг, 197 зүйл болон хавсралтаас бүрдэх бөгөөд дараах бүтэцтэй:

I бүлэг – Удиртгал (зорилго, хэрэглэх хүрээ, нэр томьёо);
II бүлэг – Нотлох баримт гаргах журам (гэрчийн мэдүүлэг, бичиг баримт, бодит зүйл болон бусад нотолгоо гаргах журам);
III бүлэг – Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл (холбогдол, дам мэдүүлэг, мэргэжлийн дүгнэлт, нууцлалын онцгойлолт, шүүхээс заавал, эсхүл сонголтоор хасах үндэслэл);
IV бүлэг – Нотлох ба баталгаа (нотлохын босго, шүүхийн анхааруулга ба чиглэл, нотлолтыг хөнгөвчлөх журам);
V бүлэг – Бусад зохицуулалт (тангараг/амлалт, баримтаар тохиролцох, журамлах нэмэлт заалт, толь бичиг ба хавсралт).

[1] Австрали. Evidence Act (1995) [2025]. Хандах: https://www.legislation.gov.au/C2004A04858/2012-07-01/text

1.2.Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын нотлох баримтын харилцааг 1975 онд батлагдсан Нотлох баримтын холбооны дүрмээр[2] зохицуулдаг бөгөөд энэхүү дүрэм нь холбооны түвшинд мөрдөгддөг. Мужийн түвшинд мужийн нотлох баримтын дүрэм, холбогдох хуулийн бүлгээр зохицуулдаг. Тухайлбал, Калифорни муж нь нотлох баримтын харилцааг бүхэлд нь багтаасан нотлох баримтын хууль (California evidence code)-аар, Техас муж Техас, Аризона, Юта зэрэг мужуудад нотлох баримтын дүрэм (Rules of Evidence)-ээр зохицуулдаг байна.

Уг дүрэм нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шударга, үр ашигтай явуулах, нотлох баримтын эрх зүйн хөгжлийг дэмжих, үнэн бодит байдлыг тогтоон шударга шийдвэр гаргах зорилготой (Rule 102).

Нотлох баримтын холбооны дүрэм нь дараах бүтэцтэй:

I бүлэг – Ерөнхий зохицуулалт (хэрэглэх хүрээ, тайлбар, зайлшгүй тайлбарын журам);
II бүлэг – Шүүхийн мэдэгдэл (маргаангүй баримтыг шууд хүлээн зөвшөөрөх);
III бүлэг – Иргэний хэрэг дэх таамаглал;
IV бүлэг – Холбогдол ба хязгаарлалт (зан төлөвийн нотолгоо, тусгай хэргүүдийн зохицуулалт);
V бүлэг – Онцгой эрх (хуульч–үйлчлүүлэгчийн нууц, төрийн нууц);
VI бүлэг – Гэрч;
VII бүлэг – Санал, шинжээчийн мэдүүлэг;
VIII бүлэг – Дам мэдүүлэг ба онцгойлолт;
IX бүлэг – Баталгаажуулалт, таних ажиллагаа;
X бүлэг – Бичиг баримт, дуу дүрсний эх хувийн нотолгоо;
XI бүлэг – Бусад зохицуулалт (хэрэглэх хүрээний онцгой тохиолдол, дүрмийн өөрчлөлт).

1.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нотлох баримттай холбоотой харилцааг *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль* болон *Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль* буюу эрүү, иргэний процессын хуулийн холбогдох зохицуулалт болон бусад хууль тогтоомжоор зохицуулдаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар[3] нотлох баримтын төрөл, зөвшөөрөгдөх нөхцөл, цуглуулах журмын талаар нарийвчлан зохицуулсан.

[2] АНУ. Federal Rules of Evidence (1975) [2024]. Хандах: https://www.uscourts.gov/forms-rules/current-rules-practice-procedure/federal-rules-evidence

[3] Солонгос. Criminal Procedure Act (1960). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=46411&lang=ENG

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн[4] “Нотлох баримт” хэмээх 3 дугаар бүлэг нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтын төрлийг нарийвчлан зохицуулсан байна.

Мөн цахим нотлох баримттай холбоотой харилцааг *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичиг ашиглах тухай хуулиар*[5] зохицуулдаг бөгөөд прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, шүүгч нарын цахим баримт солилцох, хадгалах, баталгаажуулах эрх зүйн үндсийг тогтоосон. Энэхүү хууль нь эрүүгийн процессыг цахимжуулж, үр ашигтай болгох зорилготой юм. Үүнээс гадна, тус улсын Ерөнхий прокурорын газраас гаргасан цахим криминалистикийн гарын авлагыг мөрдөн байцаалтад ашигладаг онцлогтой (Supreme Prosecutors' Office, n.d.).

1.4.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ) нь нотлох баримттай холбоотой харилцааг *Эрүүгийн шударга ёсны тухай хууль* болон *Иргэний нотлох баримтын тухай хуулиар* зохицуулдаг.

Эрүүгийн шударга ёсны тухай хуулийн[6] “Нотлох баримт” хэмээх XI бүлэгт эрүүгийн хэргийн нотлох баримтын зохицуулалтыг тусгасан. Энэ бүлэгт нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдал, хүний зан төлөвийн тухай баримт, дам мэдүүлэг, шинжээчийн тайлбар, шүүхийн дүгнэлт зэрэг асуудлыг хамардаг.

Иргэний нотлох баримтын харилцааг 1972 болон 1995 онд батлагдсан Иргэний нотлох баримтын тухай хоёр хуулиар зохицуулдаг. Эдгээр хуулиуд нь иргэний (давж заалдахгүй) шүүх хуралдаанд шинжлэх ухааны эксперт, мэргэжлийн дүгнэлт, танилцуулга илтгэл болон гадны эрх зүйн баримт зэрэг нотолгоог хэрхэн шүүхэд хүлээн авах эсэх асуудлыг нарийвчлан зохицуулдаг.

1972 оны Иргэний нотлох баримтын тухай хуулийн[7] 1 дүгээр хэсэг нь 1968 оны Иргэний нотлох баримтын тухай хуулийн зарим заалтыг өргөжүүлж, шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтаар хүлээн авах, бусад мэдэгдэл, дүгнэлтийг ашиглах, мөн гадаад хууль тогтоомжийг нотлох баримт болгон хэрэглэх зохицуулалтуудыг тодорхойлдог.

1995 оны Иргэний нотлох баримтын тухай хуулиар[8] баримт бичигт тусгагдсан мэдүүлгийн нотлох журам болон шүүхийн журмыг зохицуулсан байна.

---

[4] Солонгос. Civil Procedure Act (1960). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38478&lang=ENG

[5] Солонгос. Act on the Use of Electronic Documents in Summary Proceedings (2020). Хандах: https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=56947&key=9&type=soganelaw.klri.re.kr

[6] Их Британи. Criminal Justice Act (2003). Хандах: https://www.legislation.gov.uk/ukpga/2003/44/contents

[7] Их Британи. Civil Evidence Act (1972). Хандах: https://www.legislation.gov.uk/ukpga/1972/30/section/2

[8] Их Британи. Civil Evidence Act (1995). Хандах: https://www.legislation.gov.uk/ukpga/1995/38/contents

1.5.Канад Улс

Канад Улсад нотлох баримттай холбоотой харилцааг *Нотлох баримтын тухай*[9] бие даасан хуулиар зохицуулдаг. Тус хууль нь эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аль алинд нь хамаарах (§2) бөгөөд Холбооны болон мужийн шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ижил үйлчилдэг. Иргэний нотлох баримтын журмыг тухайн мужийн нотлох баримтын хууль эсхүл дүрмээр зохицуулдаг. Жишээлбэл, Онтарио мужид 1990 оны Нотлох баримтын тухай хуулиар, Квебек мужид иргэний хууль болон процессын журмаар зохицуулдаг.

Тус хууль нь дараах гурван бүлэг, 54 зүйл болон хавсралтаас бүрдэнэ:

I бүлэг – Нотлох баримтын ерөнхий зохицуулалт (гэрчийн мэдүүлэг, тангараг ба амлалт, шүүхийн мэдлэг, баримт бичиг, сэтгүүлчийн эх сурвалж, мужийн нотлох баримтын хууль, бусад нэмэлт зохицуулалт);

II бүлэг – Тусгай ажиллагааны журам (хэрэглэх хүрээ, тайлбар, журмын зохицуулалт);

III бүлэг – Тусгай нотлох ажиллагаа (тангараг ба амлалт, журмын онцгой зохицуулалт).

1.6.Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс (ОХУ)-д нотлох баримтыг эрүү, иргэн, захиргаа зэрэг процессын хуулиудаар тусдаа зохицуулдаг бөгөөд энэхүү судалгаанд *Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль* болон *Иргэний байцаан шийтгэх тухай хуулийг* авч үзлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн[10] “Нотлох баримт ба нотлох ажиллагаа” хэмээх III хэсэг дотроо дараах хоёр бүлэгт нотлох баримтыг зохицуулсан байна:

> 10 дугаар бүлэг - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нотлох баримт (нотлох баримтын төрөл, эх сурвалж, тэдгээрийн хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг тодорхойлж, нотолгооны хүрээг тогтоож өгдөг суурь зохицуулалтууд тусгасан байдаг);
> 11 дүгээр бүлэг - Нотлох ажиллагаа (нотлох баримт цуглуулах, шалгах, үнэлэх, ашиглах зэрэг нотлох ажиллагааны үйл явцыг нэгэн цогц үйл явц болгон тодорхойлж, нотлох баримтыг хэрэглэх хууль зүйн үндэс, зарчмуудыг тогтоосон байдаг).

Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн[11] “Нотлох баримт ба нотлох ажиллагаа” хэмээх 6 дугаар бүлэг нь шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох

---

[9] Канад. Evidence Act (1985) [2024}. Хандах: https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-5/page-1.html

[10] Орос. Уголовно-процессуальный кодекс (2001) [2025]. Хандах: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/

[11] Орос. Гражданский процессуальный кодекс (2002) [2025]. Хандах: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/

баримтыг цуглуулах, хадгалах, шинжлэх, үнэлэх бүх үе шат, оролцогчдын үүрэг, эрхийг иж бүрнээр зохицуулдаг.

1.7.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) нь нотлох баримттай холбоотой харилцааг *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль*[12] болон Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар[13] тус тус зохицуулдаг. Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хууль нь 500 зүйлтэй, нотлох ажиллагааг бүхэлд нь зохицуулдаг. Шүүх нь нотлох ажиллагааг удирдан явуулдаг.

[12] Герман. Code of Criminal Procedure (1987). Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html

[13] Герман. Code of Civil Procedure (2005) [2021]. Хандах: https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

ХОЁР. НОТЛОХ БАРИМТЫН ТӨРӨЛ

2.1.Бие даасан хууль, дүрмээр зохицуулдаг улс орнууд

2.1.1.Австралийн Холбооны Улс

Нотлох баримтын тухай хуулийн 2 дугаар бүлэгт гэрч, баримт бичиг болон бусад хэлбэрийн нотлох баримтын талаар зохицуулсан байна.

Гэрч: Хуулийн 2.1 дэх дэд бүлэг (§12-16)-т гэрчийн талаарх нийтлэг харилцааг зохицуулсан. Тухайлбал, тус дэд бүлгийн 1 дүгээр хэсэг (Division 1)-ийн 12 дугаар зүйлд гэрчлэх үүргийг “энэ хуульд өөрөөр заагаагүй бол хүн бүр гэрчлэх чадамжтай, мөн тухайн баримтын талаар гэрчлэх чадамжтай бол мэдүүлэг өгөх үүрэгтэй” гэж заасан.

Хэрэв гэрч тухайн баримтын талаар тавьсан асуултыг ойлгох чадамжгүй, эсхүл тавьсан асуултад ойлгогдохуйц хариулт өгөх чадамжгүй бөгөөд эдгээр чадамжийн дутагдлыг даван туулах боломжгүй (үүнд, сэтгэцийн, оюуны, эсхүл бие махбодийн хөгжлийн бэрхшээл зэргийг хамруулна) бол гэрчлэх чадамжгүй гэж үзнэ. Гэхдээ тухайн этгээд нь тодорхой баримтын талаар гэрчлэх чадамжгүй байгаа нь бусад баримтын талаар гэрчлэх боломжгүй гэсэн үг биш юм.

Харин тухайн этгээд гэрчлэхдээ үнэн зөв мэдүүлэх үүргээ ойлгох чадамжгүй бол тангараг өргөж гэрчлэх боломжгүйд тооцно. Дараах тохиолдолд тангараг өргөхгүйгээр гэрчийн мэдүүлэг өгч болно. Үүнд:

- шүүхээс үнэнийг хэлэхийн чухлыг тайлбарласан бол;
- гэрч өөрөө мэдэхгүй, эсхүл санахгүй байгаа асуулт тавигдаж болох бөгөөд энэ тохиолдолд шүүхэд мэдэгдэх ёстойг ойлгуулсан бол;
- үнэн ба худлыг ялган мэдэгдэх эрхийг тайлбарласан бол.

Хэрэв гэрч гэрчлэлтээ бүрэн дуусгахаас өмнө нас барсан, эсхүл чадамжгүй болсон ч түүний өмнө өгсөн мэдүүлэг хүчин төгөлдөр хэвээр байна.

Мөн хэсэг (Division 1)-ийн 17-20 дугаар зүйлд эрүүгийн хэрэгт гэрч, түүний мэдүүлэгтэй холбоотой харилцааг зохицуулсан. Тухайлбал,

- 17 дугаар зүйлд эрүүгийн хэрэгт хамтран яллагдагч нь өөрийн, эсхүл бусад яллагдагчийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй; харин хамтран яллагдагчийг тусад нь шүүхээр шийдвэрлэх тохиолдолд тэрээр гэрчийн мэдүүлэг өгч болно гэж заасан бол,
- 18 дугаар зүйлд яллагдагчийн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, эсхүл хүүхэд нь гэрчийн мэдүүлэг өгөхөөс, мөн өөрөө болон яллагдагчийн хоорондын харилцааны талаар мэдүүлэг өгөхөөс тус тус татгалзах эрхтэй гэж заасан. Гэхдээ дээрх зохицуулалт нь 16-аас доош насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт хамаарахгүй.

Хуулийн 2 дугаар хэсэг (§21-24)-т гэрчийн тангарагтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

Хуулийн 3 дугаар хэсэг (§26-36)-т мэдүүлэг өгөх ерөнхий дүрмийг зохицуулдаг. Зарим онцлог зохицуулалтаас дурдвал, шүүхийн хяналтын хүрээг тогтоож өгсөн. Жишээлбэл, гэрчийг байцаах арга хэлбэр, баримт бичиг ашиглалт, талуудын байцаалтын дараалал, гэрчтэй холбоотой этгээдийн оролцоо, зан байдал, байцаалтын үйл явцыг ил тод, тэгш явагдаж буйд хяналт тавьж, шаардлагатай шийдвэрийг гаргах эрхтэй. Гэрч

мэдүүлэг өгч байхдаа баримт бичиг ашиглан өөрийн ой санамжаа сэргээхийг зөвхөн шүүхийн зөвшөөрөлтэйгээр хийж болно.

Хуулийн 4 дүгээр хэсэг (§37-39)-т гэрчийг шууд болон дахин байцаахтай холбоотой харилцааг зохицуулсан. Шууд болон дахин байцаалтын явцад хөтөлсөн асуулт (leading question) тавихыг хориглох боловч дараах тохиолдлуудыг зөвшөөрнө. Үүнд:

- шүүхийн зөвшөөрөлтэй бол;
- оршлын шинжтэй, маргаангүй асуудалд хамаарах бол;
- талууд хуульчаар төлөөлөгдөж, эсэргүүцэл гаргаагүй бол;
- мэргэжлийн мэдлэг бүхий гэрчээс хийсвэр баримтын талаар санал авах бол.

Баримт бичиг: Хуулийн 2.2 дахь дэд бүлэг (§47-51)-т бичмэл нотлох баримтын талаар зохицуулсан. Баримт бичиг гэж мэдээллийг агуулсан аливаа тэмдэглэлийг хэлэх бөгөөд үүнд дараах зүйлсийг хамааруулна. Үүнд:

- бичвэр бүхий аливаа зүйл;
- мэргэжлийн хүн уншиж тайлбарлах боломжтой утга бүхий тэмдэг, тоо, тэмдэглэгээ, эсхүл цоолбор бүхий аливаа зүйл;
- дуу, дүрс, бичвэрийг дангаар нь, эсхүл өөр төхөөрөмжийн тусламжтай сэргээх боломжтой аливаа зүйл;
- газрын зураг, төлөвлөгөө, зураг төсөл, эсхүл гэрэл зураг.

Хуулийн 47 дугаар зүйлд зохицуулсан маргаантай баримт бичиг (document in question) нь тухайн хэргийг шийдвэрлэхэд агуулгыг нь нотлох зорилготой баримтыг хэлнэ. Харин маргаантай баримт бичгийн хуулбар гэж уг баримт бичгийг яг адил хувилбар биш боловч холбогдох бүх талаар ижил баримт бичгийг ойлгоно. Хэрэв гадаад улсад байгаа баримт бичиг нь дараах нөхцөлийг хангасан бол бичмэл нотлох баримт гэж үзнэ. Үүнд:

- нотолгоо гаргаж буй тал нь тухайн баримтыг гаргахаас өмнө дор хаяж 28 хоногийн өмнө (эсхүл журам, шүүхийн дүрмээр тогтоосон өөр хугацаанд) бусад талд уг баримтын хуулбарыг хүргүүлсэн байх;
- шүүх өөрөө ийм журмыг хэрэглэхийг зөвшөөрсөн байх.

Хэт олон, эсхүл төвөгтэй баримт бичгийг бүхэлд нь судлан шинжлэх нь хүндрэлтэй, эсхүл боломжгүй бол талуудын хүсэлтээр нэгтгэсэн хураангуй байдлаар нотолгоо гаргахыг шүүх зөвшөөрч болно.

Бусад нотлох баримт: Хуулийн 2.3 дахь дэд бүлэг (§52-54)-т бусад нотлох баримт болох үзлэгийн талаар зохицуулсан. Шүүгч талуудын хүсэлтээр туршилт, үзүүлэх ажиллагаа, эсхүл үзлэг хийх шийдвэр гаргаж болно. Шүүгч (шүүгчдийн бүрэлдэхүүнтэй бол бүрэлдэхүүнээрээ) туршилт, үзүүлэх ажиллагаа, эсхүл үзлэгийн үеэр өөрийн харсан, сонссон, ажигласанд тулгуурлан зохих үндэслэл бүхий дүгнэлт гаргаж болно.

Дам мэдүүлэг (hearsay)**:** Хуулийн 3.2 дахь дэд бүлэг (§59-75)-т дам мэдүүлэг, түүнийг нотлох баримтаар хэрэглэх талаар зохицуулсан. Дам мэдүүлгийг шууд нотлох баримтын зорилгоор хүлээн зөвшөөрөхгүй. Хуулийн 62 дугаар зүйлд зааснаар зөвхөн тухайн баримтыг өөрийн биеэр харсан, сонссон, мэдэрсэн этгээдийн өмнө хийсэн мэдүүлгийг дам мэдүүлэгт хамааруулна.

Мөн хүний эрүүл мэнд, мэдрэмж, сэтгэл хөдлөл, санаа зорилго, мэдлэг зэрэг тухайн үеийн нөхцөл байдалд холбогдох мэдүүлгийг хүлээн зөвшөөрч болно (§66A).

2.1.2.Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын Нотлох баримтын холбооны дүрэм нь холбооны шүүхийн үйл ажиллагаанд мөрдөгддөг. Тус дүрэмд зан чанар, дадал зуршил, гэрч болон шинжээчийн мэдүүлэг, дам мэдүүлэг, баримт бичиг зэрэг нотлох баримтын төрлүүдийг зохицуулсан.

Зан чанарын нотолгоо (character evidence)**:**

Дүрмийн 404 дүгээр зүйл нь хүний зан чанар, эсхүл зан чанарын шинжийг тухайн хүн тодорхой үйлдэл хийсэн эсэхийг нотлох зорилгоор ашиглахыг хориглоно. Өөрөөр хэлбэл, тухайн хүн тэрхүү зан чанарынхаа дагуу уг үйлдлийг хийсэн гэж үзүүлэх зорилготой бол баримтыг хүлээн зөвшөөрөхгүй.

Гэвч эрүүгийн хэрэгт дараах онцгой нөхцөлд зан чанарын нотолгоог зөвшөөрнө (§404). Үүнд:

- яллагдагч өөрийн зан чанарын холбогдох шинжийг нотолж болох ба хэрэв ийм нотолгоог хүлээн авсан бол прокурор уг нотлох баримтыг няцааж болно;
- дүрмийн 412 дугаар зүйлд[14] заасан хягаарлалтыг баримтлан, яллагдагч болон хохирогчийн зан чанарын холбогдох шинжийг нотолж болох ба хэрэв шүүх хүлээн авбал прокурор яллагдагчийн ижил шинж чанарыг нотлох баримтаар няцаах эрхтэй;
- хүний амь хохироосон хэрэгт, хэрэв яллагдагч хохирогчийг эхэлж халдсан гэж нотлох баримт гаргавал, прокурор уг хохирогчийн амар амгалан зан чанар (trait of peacefulness)-ыг нотлох баримтаар няцаах бүрэн эрхтэй.

Мөн зан чанар, эсхүл зан чанарын тодорхой шинжийг дараах байдлаар нотолж болно (§405). Үүнд:

- тухайн хүний нийгмийн нэр хүндийн талаарх гэрчийн мэдүүлгээр;
- санал бодлын хэлбэртэй мэдүүлгээр;
- хэрэв зан чанар нь тухайн хэргийг шийдвэрлэхэд гол элемент болж байгаа тохиолдолд тодорхой үйлдлээр.

Дадал зуршил (habit; routine practice): Хүн, эсхүл байгууллага тодорхой нөхцөлд дадал зуршлынхаа дагуу үйлдэл хийсэн болохыг нотлох зорилгоор уг дадал зуршлыг нотлох баримтаар хүлээн зөвшөөрч болно. Шүүх ийм төрлийн нотлох баримтыг баталгаажсан эсэх, эсхүл гэрч байсан эсэхээс үл хамааран хүлээн зөвшөөрч болно (§406).

Гэрч (witnesses): Дүрмийн 601-615 дугаар зүйлд гэрчтэй холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол хүн бүр гэрч байх эрхтэй бөгөөд гэрч мэдүүлэг өгөхийн өмнө үнэн зөв мэдүүлэхийн тулд тангараг өргөх, эсхүл нотлох ёстой. Шүүх өөрөө, эсхүл талуудын хүсэлтээр гэрчийг дуудаж болно. Тал бүр гэрчээс байцаалт авах эрхтэй.

Шүүх гэрчээс байцаалт авах, нотлох баримт бүрдүүлэх арга, дараалалд хяналт тавих бөгөөд үнэн бодит байдлыг тогтоох ажиллагааг үр дүнтэй болгох, цаг хугацаа

[14] Нотлох баримтын холбооны дүрмийн 412 дугаар зүйл - Бэлгийн хүчирхийллийн хэрэг: Хохирогч
а) Хориглолт. Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэх иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй. Үүнд: (1) хохирогч бусадтай бэлгийн харьцаанд орсон болохыг нотлох баримт; (2) хохирогчийн бэлгийн дур хүслийг нотлох баримт.

алдахаас зайлсхийх, гэрчийг дарамт шахалт, эвгүй байдалд орохоос хамгаалах ёстой (§611).

Шинжээчийн мэдүүлэг, санал (opinions and expert testimony)**:** Дүрмийн 7 дугаар бүлэг (§701-706)-т шинжээчийн мэдүүлэг, саналтай холбоотой харилцааг зохицуулсан. Шинжээч мэдлэг, ур чадвар, туршлага, сургууль, мэргэжлийн боловсрол зэргээр мэргэшсэн байх бөгөөд дараах шаардлагыг хангасан тохиолдолд мэдүүлэг нь хүлээн зөвшөөрөгдөнө (§702). Үүнд:

- шинжээчийн шинжлэх ухаан, техник, эсхүл тусгай мэдлэг нь шүүхэд хэргийн асуудлыг ойлгох, шийдвэрлэхэд туслахуйц байх;
- мэдүүлэг нь хангалттай баримт, өгөгдөлд үндэслэсэн байх;
- хэрэглэсэн арга, зарчим нь найдвартай байх;
- шинжээч тухайн хэрэгт эдгээр зарчим, аргыг найдвартайгаар хэрэглэсэн талаар дүгнэлтэд тусгасан байх.

Дам мэдүүлэг (hearsay): Дүрмийн 8 дугаар бүлэг (§801-§807)-т дам мэдүүлэгтэй холбоотой харилцааг зохицуулсан. Дам мэдүүлэг гэж тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд мэдүүлэг өгч байгаа гэрч өөрөө тухайн мэдүүлгийг гаргаагүй, харин тухайн мэдүүлгийг шүүхэд нотолгоо болгон гаргаж буй тал нь уг мэдүүлэгт илэрхийлэгдсэн утга үнэн гэдгийг нотлох зорилготой гаргаж буй тохиолдлыг хэлнэ (§801(c)). Мэдэгдэл (statement) гэж зөвхөн амаар хэлсэн үг бус, мөн бичвэр, дохио зангаа, тэмдэглэл зэрэг утга илэрхийлсэн аливаа илэрхийлэл байж болно (§801(a)). Энэ зохицуулалт нь дам мэдүүлгийн хүрээг өргөжүүлдэг.

Дам мэдүүлгийг ерөнхийдөө нотлох баримтаар хүлээн зөвшөөрөхгүй. Харин дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө (§802). Үүнд:

- холбогдох мужийн хуульд заасан бол;
- дүрэмд тусгайлан зөвшөөрсөн бол;
- Дээд шүүхийн тогтоосон бусад дүрэмд нийцсэн бол.

Дүрмийн 801(d)-д дам мэдүүлэгт тооцогдохгүй үндэслэлийг, харин 803-т дам мэдүүлэг хэдий ч шүүх хүлээн зөвшөөрөх нөхцөлийг нарийвчлан зохицуулсан. Хэрэв тухайн мэдүүлэг гаргасан этгээд нас барсан, шүүхэд ирж чадахгүй болсон, татгалзсан, санахгүй байгаа болон эрх зүйн үндэслэлээр мэдүүлэг өгөхөөс чөлөөлөгдсөн бол түүний мэдүүлгийг хүлээн зөвшөөрч болно (§804).

Баримт бичиг: Бичвэр (writing) гэдэгт үсэг, үг, тоо, эсхүл тэдгээртэй адилтгах байдлаар бичигдсэн аливаа тэмдэглэлийг, бичлэг (recording) гэдэгт дуу, эсхүл дүрсний бичлэг зэрэг дуу, дүрсний бичлэгийг, гэрэл зураг (photograph) гэдэгт ямар ч хэлбэрээр хадгалсан гэрэл зургийн дүрс, эсхүл түүнтэй адилтгах дүрсийг тус тус ойлгоно (§1001).

2.1.3.Канад Улс

Нотлох баримтын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт шүүх тус улсын хуулиар зөвшөөрөгдөөгүй ч найдвартай, зохистой гэж үзсэн бүх зүйлийг нотлох баримт болгон авч болох бөгөөд түүнд үндэслэн шийдвэр гаргаж болно гэж заасан.

Хуулийн 1 дүгээр бүлэгт гэрчтэй холбоотой (§4-8) харилцааг зохицуулсан. Энэ хүрээнд гэрчийн төрлийг нарийвчлан тодорхойлсон. Тухайлбал, шүүгдэгч болон түүний эхнэр/нөхөр, бие махбодын болон сэтгэхүйн бэрхшээлтэй хүний мэдүүлэг, мэргэжлийн гэрч (expert witnesses), эсрэг байр суурьтай гэрч (adverse witnesses) зэрэг орно.

Гэрч нь түүнийг гэмт хэрэгт холбогдуулах, эсхүл иргэний хэрэгт хариуцлага хүлээлгэхэд хүргэж болзошгүй тохиолдолд асуултад хариулахаас татгалзах эрхтэй.

Гэрч: Шүүх, шүүгч, эсхүл хуульд заасан бол талууд зөвшөөрснөөр нотлох баримтыг хүлээн авч, нотлох мэдүүлэг өгөхөөр хууль ёсоор дуудагдсан гэрч бүр тангараг өргөнө (§13).

Шүүгдэгч болон түүний эхнэр/нөхөр (accused and spouse): Гэмт хэрэгт буруутгагдаж буй хүн бүр, мөн (тус хэсэгт өөрөөр заагаагүй бол) яллагдагчаар татагдсан хүний эхнэр/нөхөр нь дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамт яллагдагчаар татагдсан эсэхээс үл хамааран өмгөөлөх эрх бүхий гэрч байна (§4.1). Ямар ч хүн яллагдагчтай гэрлэсэн гэсэн үндэслэлээр яллах байгууллагад албадан мэдүүлэг өгөхгүй (§4.2).

Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдүүлэг (evidence of person with disability): Хэрэв гэрч бие махбодын бэрхшээлээс шалтгаалан харилцахад хүндрэлтэй бол шүүх тухайн гэрчийн мэдүүлгийг ойлгомжтой байдлаар өгөх боломжоор хангах аливаа аргыг ашиглахыг зөвшөөрч болно. Сэтгэцийн эрүүл мэндийн бэрхшээлтэй гэрчийг 16 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлэг өгөх чадвартай гэж үзсэн бол дээрхтэй адил арга хэмжээг авна. Шүүх эдгээр арга хэрэгсэл шаардлагатай эсэхийг урьдчилан шалгаж болно (§6).

Мэргэшсэн гэрч (expert witnesses): Эрүүгийн болон иргэний аливаа шүүхийн хэлэлцүүлэг болон бусад ажиллагаанд талууд хууль, эсхүл шүүхийн практикаар санал, дүгнэлт хэлбэрийн нотлох мэдүүлэг өгөх эрх бүхий мэргэжлийн болон бусад шинжээчийг гэрчээр дуудаж болно. Гэвч шүүхийн зөвшөөрөлгүйгээр нэг тал таваас илүүгүй гэрч дуудаж болно (§7).

Гар бичмэлийн харьцуулалт (handwriting comparison): Маргаантай бичгийн үнэн зөвийг тогтоохын тулд шүүх гэрчид түүнийг баталгаатай бусад бичигтэй харьцуулан шалгахыг зөвшөөрнө (§8).

Эсрэг байр суурьтай гэрч (advise witnesses): Тал өөрөө дуудахдаа гэрчийн нэр хүндийг ерөнхий байдлаар гутааж болохгүй. Харин гэрч эсрэг байр суурьтай байвал тухайн мэдүүлгийг бусад баримтаар няцаах, эсхүл өмнөх мэдүүлэгтэй зөрчилдөж буйг нотолж болно.

Баримт бичиг (documentary evidence)**:** Хуулийн 19-36 дугаар зүйлд дараах баримт бичгийн төрлийг заасан. Үүнд:

- Парламентын болон мужийн хууль тогтоомжийн албан ёсны хэвлэл нь нотлох баримтад шууд тооцогдоно (§19-22);
- гадаад[15] болон дотоодын шүүх, шүүгч, шүүхийн бичээчийн протокол, шийдвэр, тэмдэглэл нь тамга, гарын үсэгтэй бол дахин нотлохгүйгээр хүлээн авна (§23);
- баталгаажуулсан хуулбар (§24);

[15] Нотлох баримтын тухай хуулийн 23(1). Их Британи дахь аливаа шүүх, Канадын Дээд шүүх, Холбооны Давж заалдах шатны шүүх, Холбооны шүүх, эсхүл Канадын Татварын шүүх, муж улсын аливаа шүүх, Британий колони, эсхүл харьяалал дахь шүүх, АНУ-ын аливаа бүртгэл хөтөлдөг шүүх, АНУ-ын муж улсын шүүх, эсхүл өөр гадаад улсын шүүх, мөн муж улсын шүүхийн захирагч (justice of the peace), эсхүл задлан шинжээч (coroner)-ийн өмнө хийгдсэн аливаа ажиллагаа, эсхүл бүртгэлийн нотолгоог тухайн ажиллагаа, эсхүл бүртгэлийн баталгаажуулсан хуулбар буюу гэрчилгээтэй хувилбараар гаргаж болох бөгөөд энэ нь тухайн шүүхийн тамга, эсхүл шүүхийн захирагч, задлан шинжээч, эсхүл шүүхийн бичээчийн гарын үсэг, тамгатай байна. Энэ тохиолдолд тухайн тамга, гарын үсгийн жинхэнэ эсэхийг нотлох, эсхүл өөр ямар нэгэн нэмэлт нотолгоо гаргах шаардлагагүй.

- ном, эсхүл бусад баримт бичиг нь нийтийн шинжтэй тул түүнийг зөвшөөрөгдсөн этгээдийн хадгалалтаас шууд гарган үзүүлэхэд нотлох баримтаар хүлээн авч болно (§25);
- Канад Улсын Засгийн газрын дэргэдэх байгууллагуудад хадгалагдаж байгаа номууд (§26);
- Квебек мужийн нотариатын баримт бичгийн хуулбар (§26)[16];
- санхүүгийн байгууллагын бүртгэлийн хуулбар (§29);
- байгууллагын өдөр тутмын бүртгэл (§30(1), 30(3));

Цахим нотлох баримт: Цахим баримт бичгийг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрөхийг хүссэн аливаа этгээд тухайн цахим баримт бичгийг өөрөө нотлох баримтаар нотлох үүрэгтэй (§31.1-8);

2.2.Эрүүгийн болон иргэний процессын хуулиар зохицуулдаг улс орнууд

2.2.1.Бүгд Найрамдах Солонгос Улс

а) <u>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Тус хуульд үзлэг, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн нотлох баримт зэрэг нотлох баримтын төрлүүдийг дараах байдлаар зохицуулсныг авч үзье.

Үзлэг: Хуулийн XI бүлэг (§139-145)-т үзлэгтэй холбоотой харилцааг зохицуулсан. Тус бүлэгт шаардлагатай бол шүүх үзлэг хийж болох бөгөөд шөнийн цагаар үзлэг хийх хязгаарлалт, эмэгтэй хүний биед үзлэг хийх бол эмч/эмэгтэй хүн байлцуулах, цогцсыг хүндэтгэх зэрэг журмыг зохицуулсан.

Гэрч: Хуулийн XII бүлэг (§146-168)-т гэрчтэй холбоотой харилцааг зохицуулсан. Хуулийн 146 дугаар зүйлд хуульд (өөрөөр заагаагүй бол) шүүх хэнийг ч гэрчээр байцааж болно гэж заасан. Хэрэв төрийн албан хаагч, эсхүл төрийн албан хаагч байсан этгээд үүргээ гүйцэтгэх явцдаа мэдсэн баримтыг өөрөө, эсхүл тухайн байгууллагаас албан ёсоор төрийн нууцад хамаарна гэж мэдэгдсэн бол тухайн байгууллагын зөвшөөрөлгүйгээр гэрчээр байцаахыг хориглоно.

Гэрч нь төрөл садан, эсхүл хамаатан, хууль ёсны төлөөлөгч, эсхүл асран хамгаалагчийнхаа эсрэг гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.

Гэрчийг зарлан дуудах бичиг, утас, цахим шуудангаар дуудаж болох бөгөөд хүрэлцэн ирээгүй тохиодолд торгууль ногдуулах, дахин ирээгүй бол долоо хүртэл хоног саатуулах албадлагын арга хэмжээ авна.

Хохирогчийн нас, сэтгэцийн болон биеийн байдлыг харгалзан итгэлтэй харилцаатай хүнийг хамт байлцуулж болох бөгөөд хүүхэд, өсвөр насныхан болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг дуу, дүрс дамжуулах хэрэгсэл ашиглан мэдүүлэг авч болно.

[16] Нотлох баримтын тухай хуулийн 27. Квебек мужид үйлдэгдсэн, хадгалсан, эсхүл бүртгэсэн нотариатын баримт бичиг хуулбар гэж үзэгдэх, мөн тухайн нотариат, эсхүл шүүхийн бичиг хэргийн эрхлэгч (prothonotary)-ийн гарын үсгээр баталгаажсан, өөрийн эзэмшилд буй эх хувийн үнэн зөв хуулбар болохыг нотолсон аливаа баримтыг нотлох баримтаар эх хувийн оронд хүлээн авч, шүүхэд эх хувь гарган ирүүлж, нотолсонтой адил хүчинтэйд тооцно.

Шинжээчийн нотлох баримт (expert evidence): Хуулийн XIII дугаар бүлэг (§169-179)-т шинжээчийн нотлох баримттай холбоотой харилцааг зохицуулсан. Шүүх мэргэжил, туршлагатай хүнийг шинжээчээр томилж, тангараг өргүүлнэ. Шинжээч дүгнэлтээ бичгээр гаргах бөгөөд шүүх шаардлагатай гэж үзвэл аман тайлбар авна. Шаардлагатай бол шүүхийн гадна шинжилгээ хийхийг зөвшөөрнө. Мөн сэжигтний сэтгэц/биеийн байдлыг тогтоох зорилгоор тодорхой хугацаагаар эмнэлэгт албадан байруулж болно. Энэ үед:

- шинжилгээний зорилгоор саатуулах тухай тусгай баривчлах зөвшөөрөл олгоно;
- саатуулах хугацааг сунгах/богиносгох эрхтэй;
- саатуулах хугацааг яллагдагчийн цагдан хоригдсон хоногт тооцно.

Шинжээч нь шүүхийн зөвшөөрлөөр орон сууц, эд хөрөнгөд нэвтрэх, үзлэг хийх, цогцсыг задлан шинжлэх, булш нээх, эд зүйл эвдэх онцгой эрхтэй бөгөөд хэрэгт хамаарах бичиг баримт, эд мөрийн баримтыг үзэж танилцах, хуулбарлах, шүүгдэгч, гэрчийн байцаалтад байлцах, асуулт асуух, эсхүл шууд байцаах эрхтэй.

б) <u>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 288 дугаар зүйлд зааснаар шүүхэд талуудын хүлээн зөвшөөрсөн баримт болон нотлох баримтад баталгаажуулалт шаардахгүй. Талууд нотлох баримтыг шинжлүүлэх хүсэлт гаргахдаа нотлох баримтыг тодорхойлон зааж өгөх бөгөөд энэхүү хүсэлтийг мэдүүлэг өгөх өдрөөс өмнө ч гаргаж болно.

Хуулийн III дугаар бүлэгт гэрчийн мэдүүлэг, шинжээчийн мэдүүлэг, бичмэл нотлох баримт, хяналт шалгалт болон бусад нотлох баримт гэсэн таван төрлийн нотлох баримтыг хуульчилсан байна.

Гэрчийн мэдүүлэг: Хуулийн 2 дугаар хэсэг (Section 2, §303-332)-т гэрчтэй холбоотой харилцааг зохицуулсан. Шүүх (энэ хуульд өөрөөр заагаагүй бол) хэнийг ч гэрчээр байцааж болох бөгөөд гэрч мэдүүлэг өгөхийн өмнө тангараг өргөнө.

Шүүх тус улсын Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблейн дарга, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон тэдгээрийг өмнө эрхэлж байсан албан тушаалын албаны нууцтай холбоотой асуудлаар гэрчээр мэдүүлэг авах тохиолдолд тухайн этгээд болон холбогдох байгууллагаас зөвшөөрөл авна. Харин төрийн албан хаагч болон өмнө нь уг албан тушаалыг эрхэлж байсан этгээдийг албаны нууцтай холбоотой асуудлаар гэрчээр мэдүүлэг авах бол харьяалах буюу хяналтын чиг үүрэг бүхий төрийн байгууллагын зөвшөөрлийг авна.

Гэрчид гэрчээр дуудсан тухай зарлан дуудах хуудас хүргүүлэх бөгөөд түүнд талуудын тодорхойлолт, мэдүүлэг авах агуулгын товч болон ирээгүй тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагаврын талаар тусгасан байна. Гэрч ирээгүй тохиолдолд мөнгөн торгууль, баривчлах, албадан ирүүлэх хүртэл албадлагын арга хэмжээ авч болно.

Гэрч нь өөрийгөө болон өөрийн хамаатан садан, өмнө нь ийм харилцаатай байсан этгээд, асран хамгаалагч, эсхүл асрамжинд нь байгаа этгээдийг яллах, өөрийгөө болон тэдний нэр төрийг гутаан доромжлоход хүргэж болзошгүй бол гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй бөгөөд татгалзах үндэслэлээ нотлох ёстой. Шүүх мэдүүлэг өгөхөөс татгалзсан нь үндэслэлтэй эсэхийг шинжлэн хянан шийдвэрлэнэ. Гэрч нь дүрс болон цахим дамжуулалтын систем ашиглан гэрчийн мэдүүлэг өгөх боломжтой.

Шинжээчийн мэдүүлэг (expert testimony)**:** Хуулийн 3 дугаар хэсэг (§333-342)-т шинжээчийн мэдүүлгийн талаар зохицуулсан. Шинжээчийн мэдүүлэгт гэрчийн мэдүүлэгтэй холбоотой журмыг хэрэглэх бөгөөд шинжээчийг тухайн хэргийг хянан

шийдвэрлэж буй шүүх, бүрэлдэхүүний шүүгч, эсхүл даалгасан шүүгч томилно. Талууд шинжээч үнэн зөв дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байвал татгалзах хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд хүсэлтээ нотлох ёстой. Шинжээч нь дүгнэлтээ амаар, бичгээр, олон шинжээч хамтдаа, эсхүл тус тусдаа гаргаж болно. Шүүхийн зөвшөөрлөөр шинжээч газар, байр, тээврийн хэрэгсэл, бусад байгууламжид нэвтэрч болох бөгөөд саад учирвал цагдаагийн байгууллагын туслалцаа авч болно.

Бичмэл нотлох баримт: Хуулийн 4 дүгээр хэсэг (§343-363)-т бичмэл нотлох баримттай холбоотой харилцааг зохицуулсан. Талууд бичиг баримтыг нотлох баримтаар гаргахдаа тухайн баримтыг өөрөө шүүхэд гаргах, эсхүл түүнийг хадгалж буй этгээдээр гаргуулах талаар шүүхийн журмаар хүсэлт гаргана. Бичмэл нотлох баримтыг гаргах үүрэгтэй бөгөөд төрийн нууц, гэр бүлийн хувийн нууц, мэргэжлийн нууц (эмч, өмгөөлөгч, нягтлан бодогч гэх мэт) бүхий баримтыг гаргаж өгөхөөс татгалзаж болох бөгөөд дараах тохиолдолд татгалзах эрхгүй. Үүнд:

- тухайн баримт нь хэрэг маргаанд иш татагдсан бол;
- хүсэлт гаргагч нь баримтыг шилжүүлэн авах, эсхүл үзэх эрхтэй бол;
- баримтыг хүсэлт гаргагчийн ашиг тусын тулд, эсхүл хүсэлт гаргагч болон баримтыг хадгалж буй этгээдийн хоорондын эрх зүйн харилцаанд холбогдуулан үйлдсэн бол.

Баримт гаргуулах шүүхийн тогтоол биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ:

- хэрэв баримт гаргуулах тогтоолыг биелүүлээгүй бол шүүх эсрэг талын мэдүүлгийг үнэн гэж үзэж болно;
- аль нэг тал баримтыг ашиглуулах боломжийг хаах зорилгоор зориуд устгасан буюу ашиглах боломжгүй болгосон бол шүүх эсрэг талын мэдүүлгийг үнэн гэж үзэж болно.

Харин хувийн баримтын үнэн зөвийг нотлох шаардлагатай бөгөөд тухайн этгээд, эсхүл төлөөлөгчийн гарын үсэг, тамга, эсхүл хурууны хээгээр баталгаажсан бол үнэн зөв гэж үзнэ.

Хэрэв тал баримтын үнэн зөвийг санаатайгаар, эсхүл хайхрамжгүй байдлаар эсэргүүцсэн бол шүүх хоёр сая воноос хэтрэхгүй захиргааны торгууль ногдуулна.

Хяналт шалгалт: Хуулийн 5 дугаар хэсэг (§367-373)-т хяналт шалгалт хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Аль нэг тал хяналт шалгалт хийлгэх хүсэлт гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд шалгалтын зорилгыг заавал зааж өгнө. Хяналт шалгалтын үед шүүгч, итгэмжлэгдсэн шүүгч шинжээч, эсхүл томилогдсон гэрчээс мэдүүлэг авч болно.

Бусад нотлох баримт: Хуулийн 6 дугаар хэсэг (§343-363)-т бусад нотлох баримттай холбоотой харилцааг зохицуулсан. Тухайлбал, баримт бичиг биш, харин зураг, гэрэл зураг, соронзон бичлэгийн хальс, дуу/дүрс бичлэг, компьютерт зориулсан соронзон диск болон тэдгээрт мэдээлэл оруулах зорилгоор бүтээсэн бусад эд зүйл зэрэг баримт бичиг бус нотолгоог Улсын дээд шүүхийн журмаар зохицуулна.

2.2.2.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Иргэний нотлох баримтын тухай хуулиар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нотлох баримтын төрлийг дам мэдүүлэг, ерөнхий эрх зүйн уламжлал, гэрчийн мэдүүлэг, баримт бичиг болон шинжээчийн дүгнэлт зэргийг нарийвчлан

зохицуулсан. Эрүүгийн болон иргэний процессын хууль дахь нотлох баримтын төрлүүдийн талаар авч үзье.

а) <u>Эрүүгийн шударга ёсны тухай хуулийн зохицуулалт:</u>

Эрүүгийн шударга ёсны тухай хуулийн XI бүлэгт эрүүгийн хэргийн нотлох баримтын талаар зохицуулсан бөгөөд муу зан чанар, дам мэдүүлэг, аман мэдүүлэг, баримт бичиг, шинжээчийн нотолгоо болон дүрс бичлэг зэрэг нотлох баримтын төрлүүдийг зохицуулсан.

Муу зан чанар (bad character): Хуулийн 98 дугаар зүйлд зааснаар муу зан чанарын нотлох баримт гэдэг нь тухайн хүний зүй бус үйлдэл (misconduct)-д холбогдох, эсхүл зүй бус үйлдэл хийх хандлагыг илтгэх нотлох баримтыг хэлнэ. Гэхдээ (а) яллагдагчид холбогдуулан буруутгаж буй гэмт хэргийн үйлдэгдсэн гэх баримтуудтай холбоотой нотлох баримт, (б) тухайн гэмт хэргийг мөрдөн шалгах, эсхүл яллах ажиллагаатай холбогдуулан гарсан зүй бус үйлдэл нотлох баримтад хамаарахгүй. Яллагдагчаас бусад этгээдийн муу зан чанар болон яллагдагчийн муу зан чанарыг тус тусад нь зохицуулсан.

Дам мэдүүлэг (hearsay): Хуулийн 114-136 дугаар зүйлд дам мэдүүлгийн талаар зохицуулсан бөгөөд амаар өгсөн мэдүүлэг бус мэдэгдэл (statement not made in oral evidence) гэх бөгөөд дараах нөхцөлд л тухайн мэдэгдэлд заасан асуудлыг нотлох баримт болгон зөвшөөрнө. Үүнд:

- энэ бүлэг, эсхүл өөр хууль тогтоомжид тусгайлан зөвшөөрсөн бол;
- хуулийн 118 дугаар зүйлд заасан нийтлэг эрх зүйн дүрмээр хүлээн зөвшөөрсөн бол;
- оролцогч талууд тухайн мэдэгдлийг зөвшөөрөхөөр тохиролцсон бол;
- шүүхээс тухайн мэдэгдлийг зөвшөөрөх нь шударга ёсны ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн бол.

Дам мэдүүлгийг хүлээн авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

Баримт бичиг (business and other documents): Баримт бичиг (document) гэдэг нь аливаа мэдээллийг ямар нэгэн байдлаар тэмдэглэн үлдээсэн зүйл бөгөөд дуу, эсхүл хөдөлгөөнт дүрсний бичлэгийг хамааруулахгүй (§140).

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримт бичигт тусгагдсан мэдэгдэл нь дараах тохиолдолд нотлох баримтаар зөвшөөрөгдөнө. Үүнд:

- хэрэг уг асуудлын талаар тухайн этгээд амаар мэдүүлэг өгсөн бол зөвшөөрөгдөх байсан бол;
- баримт бичиг буюу мэдэгдэл агуулсан хэсгийг тухайн этгээд худалдаа, бизнес, мэргэжил, эсхүл бусад ажил мэргэжлийн хүрээнд, эсхүл цалинтай болон цалингүй албан тушаалын хүрээнд бүтээсэн, эсхүл хүлээн авсан байх;
- мэдэгдэлд тусгагдсан мэдээллийг өгсөн этгээд тухайн асуудлыг өөрийн биеэр мэдэж байсан, эсхүл мэдэж байсан нь үндэслэлтэйгээр таамаглахуйц байх.

Шинжээчийн нотолгоо: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч мэдүүлэг өгөхдөө тухайн мэдэгдэлд тулгуурлан дүгнэлт, эсхүл таамаглал гаргаж болно. Хэрэв мэдэгдэлд тулгуурласан нотолгоо гаргавал уг мэдэгдэл, түүний агуулгыг нотлох баримт гэж үзнэ. (§127)

Дүрс бичлэг (video recording) гэдэг нь аливаа хэлбэрийн медиа дээр хийсэн, хөдөлгөөнт дүрсийг ямар нэгэн аргаар гаргаж болох бичлэг бөгөөд түүнд хавсарсан дууны бичлэгийг мөн хамруулна (§140). Дүрс бичлэгийг нотлох баримтаар ашиглахдаа дараах асуудлыг харгалзан үзнэ (§137). Үүнд:

- тухайн үйл явдал болсон үе болон бичлэг хийгдсэн үеийн хоорондын хугацаа;
- гэрч тухайн бичлэгт хэлсэн зүйлсийн найдвартайд нөлөөлөх бусад хүчин зүйлс;
- бичлэгийн чанар;
- гэрчийн байр суурь.

Хэрэв гэрч шүүхийн ажиллагаанд амаар мэдүүлэг өгөхдөө бичлэгт гарсан мэдүүлгийнхээ үнэн зөвийг баталсан бол шүүхийн ажиллагаанд амаар өгсөнтэй адилтгаж үзнэ.

б) <u>Иргэний нотлох баримтын тухай хуулиудын зохицуулалт:</u>

1972 оны Иргэний нотлох баримтын тухай хуулиар шинжээчийн дүгнэлт, шинжээчийн мэдүүлэгтэй холбоотой шүүхийн журам, хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар зохицуулсан. 1995 оны Иргэний нотлох баримтын тухай хуулиар дам мэдүүлэг, баримт бичигт тусгагдсан мэдүүлгийн нотлох журам болон шүүхийн журмын талаар зохицуулсан. Дээрх хоёр хуульд зохицуулсан нотлох баримтын төрлийн талаар авч үзье.

Шинжээчийн дүгнэлт: 1972 оны Иргэний нотлох баримтын тухай хуулиар шинжээчийн дүгнэлттэй холбоотой харилцааг зохицуулсан. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн шатанд талууд өөрийн нотолгооны нэг хэсэг болгон эмнэлгийн шинжилгээний асуудал болон бусад асуудлаарх (шүүхийн заалтаар тодорхойлж болно) шинжээчийн дүгнэлтийг тодорхой хугацаанд нөгөө талдаа ил болгоно. Хэрэв шүүхийн журмын дагуу өгөгдсөн чиглэлийг биелүүлээгүй этгээд нь шүүхийн зөвшөөрөлгүйгээр шинжээчийн дүгнэлтэд агуулагдсан аливаа мэдээллийг нотлох баримт болгон гаргах эрхгүй.

Дам мэдүүлэг (Hearsay evidence): Хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар дам мэдүүлэг гэж тухайн хэрэгт аман мэдүүлэг өгч буй этгээдээс өөр этгээд өмнө нь гаргасан мэдэгдлийг, уг мэдэгдэлд дурдсан асуудлыг батлах зорилгоор нотлох баримтад ашиглаж буй тохиолдлыг хэлнэ. Нэг тал дам мэдүүлгийг нотлох баримтаар ашигласан боловч тухайн мэдэгдлийг хийсэн хүнийг гэрчээр оруулаагүй бол нөгөө тал шүүхийн зөвшөөрөлтэйгөөр түүнийг гэрчээр байцаан шалгах эрхтэй. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд, хэрэв дам мэдүүлгийн нотлох баримт нь тухайн мэдэгдлийг хийсэн этгээд тухайн үедээ гэрчээр мэдүүлэг өгч чадахгүй байсан гэдэг нь тогтоогдсон бол, эсхүл батлагдсан бол ийм нотлох баримтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй.

Ерөнхий эрх зүйн уламжлал: Үр нөлөөг хадгалсан ерөнхий эрх зүйн дүрмүүд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүчин төгөлдөр байна (§7). Үүнд:

- олон нийтэд хамааралтай асуудлыг хөндсөн, хэвлэгдсэн бүтээлүүд (жишээлбэл, түүхийн зохиол, шинжлэх ухааны бүтээл, толь бичиг, газрын зураг гэх мэт);
- олон нийтийн баримт бичиг (жишээлбэл, улсын бүртгэл, олон нийтийн ашиг сонирхлын хүрээнд төрийн байгууллагын албан ёсоор гаргасан тайлан, мэдээ);
- албан ёсны бүртгэл, тэмдэглэлүүд (жишээлбэл, зарим шүүхийн тэмдэглэл, гэрээ, хааны өршөөл, эрх олголт, комиссын шийдвэр гэх мэт).

Баримт бичиг: Баримт бичиг гэдэг нь ямар ч төрлийн мэдээлэл агуулсан бичиг баримт, материал, бичлэгийг хэлнэ. Хуулбар гэж тухайн баримт бичигт бичигдсэн мэдээллийг ямар ч аргаар, шууд, эсхүл дам байдлаар хувилан буулгасан аливаа материалыг хэлнэ (§13). Баримт бичигт тусгагдсан мэдэгдлийг нотлох баримтаар зөвшөөрөгдөх бол дараах байдлаар нотолно (§9). Үүнд:

- тухайн баримт бичгийг гаргаж үзүүлэх замаар;

- тухайн баримт бичиг байгаа эсэхээс үл хамааран уг баримт бичгийн хуулбар буюу холбогдох хэсгийн хуулбар (шүүхээс хүлээн зөвшөөрсөн хэлбэрээр баталгаажуулсан байх ёстой)-ыг гаргаж үзүүлэх замаар.

Хэрэв баримт бичиг нь аж ахуй нэгжийн, эсхүл төрийн байгууллагын бүртгэлийн нэг хэсэг болох нь тогтоогдвол, уг баримт бичгийг нэмэлт нотолгоо шаардахгүйгээр хүлээн авна. Баримт бичиг нь аж ахуй нэгжийн, эсхүл төрийн байгууллагын бүртгэлийн нэг хэсэг боолохыг тогтоохдоо тухайн байгууллагын албан тушаалтны гарын үсэг зурсан гэрчилгээг шүүхэд гаргаж үзүүлнэ (§9).

2.2.3.Оросын Холбооны Улс

а) <u>Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэрэгт хамаарах нотлох баримт гэж тус хуульд заасан журмын дагуу шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгчийн тогтоосон, хэрэг хянан шийдвэрлэх явцад тогтоох ёстой нөхцөл байдлын оршин байгаа эсэх, түүнчлэн эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий бусад нөхцөл байдлыг нотлох үндэслэл болох аливаа мэдээ, мэдээллийг ойлгоно (§74.1).

Нотлох баримтад дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө (§74.2). Үүнд:

- сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг;
- хохирогч, гэрчийн мэдүүлэг;
- шинжээчийн дүгнэлт болон түүний мэдүүлэг;
- мэргэжилтний дүгнэлт болон түүний мэдүүлэг;
- биет нотлох баримт;
- мөрдөн шалгах болон шүүх ажиллагааны протоколууд;
- бусад бичиг баримт.

Сэжигтний мэдүүлэг: Сэжигтний мэдүүлэг гэж хуульд заасан 187–190 дүгээр зүйлийн шаардлагын дагуу урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааны явцад авсан байцаалтын үед түүнээс өгсөн мэдээ, мэдээллийг ойлгоно (§76).

Яллагдагчийн мэдүүлэг: Яллагдагчийн мэдүүлэг гэж эрүүгийн хэрэгт холбогдуулан урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүхийн шатанд, энэ хуулийн 173, 174, 187–190 болон 275 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу авсан байцаалтын үеэр түүний өгсөн мэдээ, мэдээллийг ойлгоно.

Яллагдагч гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн мэдүүлгийг дангаар нь буруутай гэж үзэх үндэслэл болгон ашиглаж үл болно. Ийм мэдүүлгийг зөвхөн хэрэгт цуглуулсан бусад нотлох баримтын нийлбэрээр баталгаажсан тохиолдолд л яллах дүгнэлтийн үндэслэл болгоно (§77).

Хохирогчийн мэдүүлэг: Хохирогчийн мэдүүлэг гэж эрүүгийн хэрэгт холбогдуулан урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүхийн шатанд, энэ хуулийн 187–191 болон 277 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу авсан байцаалтын үеэр хохирогчоос өгсөн мэдээ, мэдээллийг ойлгоно.

Хохирогчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад тогтоох ёстой аливаа нөхцөл байдлын талаар байцааж болно. Үүнд, түүнтэй сэжигтэн, эсхүл яллагдагчийн хоорондын харилцааны талаарх мэдүүлэг ч багтана (§78).

Гэрчийн мэдүүлэг: Гэрчийн мэдүүлэг гэж эрүүгийн хэрэгт холбогдуулан урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүхийн шатанд, энэ хуулийн

187–191 болон 278 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу авсан байцаалтын үеэр гэрчийн өгсөн мэдээ, мэдээллийг ойлгоно.

Гэрчийг эрүүгийн хэрэгт хамаарах аливаа нөхцөл байдлын талаар байцааж болно. Үүнд, яллагдагч болон хохирогчийн хувийн байдал, түүнчлэн гэрчийн тэдэнтэй болон бусад гэрч нартай тогтоосон харилцааны талаарх мэдүүлэг орно (§79).

Шинжээч болон мэргэжилтний дүгнэлт, мэдүүлэг:

- шинжээчийн дүгнэлт гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй эрх бүхий албан тушаалтан, эсхүл талуудын тавьсан асуултад шинжээчийн хийсэн судалгааны агуулга болон түүний дүгнэлтийг бичгээр илэрхийлсэн баримтыг ойлгоно;
- шинжээчийн мэдүүлэг гэж түүний дүгнэлтийг гаргасны дараа авсан байцаалтын үеэр, уг дүгнэлтийг тайлбарлах, тодруулах зорилгоор өгсөн мэдээ, мэдээллийг ойлгоно. Энэ нь энэхүү хуулийн 205, 282 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байна;
- мэргэжилтний дүгнэлт гэж талуудын тавьсан асуултад хариулан тухайн асуудлаар мэргэжилтний гаргасан бичгээр илэрхийлсэн байр суурийг ойлгоно;
- мэргэжилтний мэдүүлэг гэж мэргэжилтэн тусгай мэдлэг шаардагдах нөхцөл байдлын талаар өгсөн мэдээ, мэдээлэл болон өөрийн дүгнэлтийг тайлбарласан мэдүүлгийг ойлгоно. Энэ нь энэхүү хуулийн 53, 168 болон 271 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцсэн байна (§80).

Биет нотлох баримт: Биет нотлох баримт гэж (1) гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдсан зэвсэг, тоног төхөөрөмж болон бусад хэрэгсэл, эсхүл гэмт хэргийн ул мөрийг өөртөө хадгалсан зүйлс, (2) гэмт хэргийн үйлдэлд шууд хамааралтай байсан объект, (3) гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олдсон мөнгө, үнэт зүйлс болон бусад эд хөрөнгө болон (4) гэмт хэргийг илрүүлэх, эрүүгийн хэргийн нөхцөл байдлыг тогтооход ашиглаж болох бусад эд зүйл, баримт бичгийг ойлгоно (§81.1, 84.4).

Мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл: Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл болон шүүх хуралдааны тэмдэглэлийг энэ хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд нотлох баримтад тооцон ашиглаж болно (§83).

Бусад бичиг баримт: Бусад бичиг баримтыг энэ хуулийн 73 дугаар зүйлд заасан нөхцөл байдлыг тогтооход ач холбогдолтой мэдээлэл агуулсан тохиолдолд нотлох баримтад тооцон ашиглаж болно (§84.1). Бичиг баримтад мэдээлэл нь бичгээр, эсхүл өөр хэлбэрээр тусгагдсан байж болно. Үүнд гэрэл зураг, кино зураг, дуу болон дүрсний бичлэг, түүнчлэн энэ хуулийн 86 дугаар зүйлд заасан журмын дагуу авсан, гаргуулсан, эсхүл талуудын гаргасан бусад мэдээллийн эх сурвалжууд хамаарна (§84.2).

б) <u>Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуулийн 55 дугээр зүйлд зааснаар иргэний хэрэгт хамаарах нотлох баримт гэж хуульд заасан журмын дагуу авсан, тухайн маргааныг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримтуудын оршин байгаа эсэхийг тогтоох үндэслэл болох, талуудын шаардлага, эсэргүүцлийг нотлох болон хэргийн зөв шийдвэрлэлд хамаарах бусад нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг ойлгоно (§55.1).

Нотлох баримтад дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- талууд болон гуравдагч этгээдийн тайлбар (объяснения сторон и третьих лиц);
- гэрчийн мэдүүлэг;
- бичиг баримт (письменные доказательства);

- биет нотлох баримт;
- дуу болон дүрсний бичлэг;
- шинжээчийн дүгнэлт.

Талууд болон гуравдагч этгээдийн тайлбар: Хэрэгт ач холбогдол бүхий, өөрт нь мэдэгдэж байгаа нөхцөл байдлын талаар талууд болон гуравдагч этгээдийн өгсөн тайлбар нь бусад нотлох баримтын адил шалгагдаж, үнэлэгдэх ёстой. Хэрэв өөрийн шаардлага, эсэргүүцлийг нотлох үүрэг хүлээсэн тал өөр дээрээ буй нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөхөөс зайлсхийвэл, шүүх нөгөө талын тайлбарт үндэслэн дүгнэлт хийж болно (§68.1).

Талууд болон гуравдагч этгээдийн тайлбар, гэрчийн мэдүүлгийг энэхүү хуулийн 155.1 дүгээр зүйлд заасан журмын дагуу видео хурлын систем ашиглан, эсхүл 155.2 дугаар зүйлд заасан журмын дагуу вэб хурлын систем ашиглан авч болно (§55.1).

Гэрчийн мэдүүлэг: Гэрч гэж тухайн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар ямар нэгэн мэдээ, мэдээлэл мэдэж байж болох этгээдийг ойлгоно. Харин гэрч өөрийн мэдэж буй мэдээ, мэдээллийн эх сурвалжийг зааж чадахгүй бол түүний өгсөн мэдүүлэг нь нотлох баримтад тооцогдохгүй (§69.1).

Гэрчийг дуудах хүсэлт гаргаж буй этгээд тухайн гэрч ямар нөхцөл байдлыг нотолж чадахыг тодорхой зааж, мөн гэрчийн нэр, эцгийн нэр, овог болон оршин суугаа газрыг шүүхэд мэдүүлэх үүрэгтэй (§69.2).

Хуулийн 69 дүгээр зүйлд гэрчээр байцаахгүй этгээдийг хуульчилсан (§69.3). Үүнд:

- иргэний, эсхүл захиргааны хэрэгт өмгөөлөгч, төлөөлөгч; эрүүгийн болон захиргааны хэрэгт өмгөөлөгч (хамгаалагч); медиатор болон шүүхийн эвлэрүүлэгч зэрэг этгээдийн мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэх явцад мэдсэн нөхцөл байдлын тухайд;
- шүүгч, тангарагтан, эсхүл арбитрын шүүгч нарын хэргийн нөхцөл байдлыг хэлэлцэн шүүхийн шийдвэр, ял гаргахтай холбогдон зөвлөлдөх өрөөнд яригдсан асуудлын тухайд;
- улсын бүртгэлтэй шашны байгууллагын шашны зүтгэлтнийг өмгөөллийн нууцаар мэдсэн нөхцөл байдлын тухайд;
- арбитрчийн арбитрын маргааны явцад мэдсэн нөхцөл байдлын тухайд.

Түүнээс гадна хуульд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах этгээдүүд, албан тушаалтнуудыг нарийвчлан тогтоосон байна (§69.4). Үүнд:

- иргэн өөрийнхөө эсрэг;
- гэр бүлийн гишүүд хоорондоо (нөхөр, эхнэр; эцэг эх, үр хүүхэд (үрчлэгдсэн хүүхэд орно); ах, эгч; өвөө, эмээ, ач, зээ) бие биенийхээ эсрэг мэдүүлэг өгөх тухайд;
- хууль тогтоох байгууллагын депутатууд нь депутатын бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад мэдсэн мэдээллийн тухайд;
- ОХУ-ын Хүний эрхийн төлөөлөгч, Хүүхдийн эрхийн төлөөлөгч, Бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах төлөөлөгч болон холбооны субъектүүдийн ижил төлөөлөгчид нь өөрийн албан үүргээ хэрэгжүүлэх явцад мэдсэн мэдээллийн тухайд.

Гэрч гэж тухайн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар ямар нэгэн мэдээ, мэдээлэл мэдэж байж болох этгээдийг ойлгоно. Харин гэрч

өөрийн мэдэж буй мэдээ, мэдээллийн эх сурвалжийг зааж чадахгүй бол түүний өгсөн мэдүүлгийг нотлох баримтад тооцохгүй.

Бичиг баримт: Бичгийн нотлох баримт гэж хэрэг хянан шийдвэрлэх болон шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдээлэл агуулсан акт, гэрээ, тодорхойлолт, албан болон аж ахуйн захидал харилцаа, түүнчлэн цахим болон график бичлэгийн хэлбэрээр хийгдсэн бусад баримт бичиг, материалыг ойлгоно. Бичгийн нотлох баримтад цахим болон бусад хэлбэрээр хийгдэж, үнэн зөвийг тогтоох боломжтой баримтууд, мөн шүүхийн шийдвэр, тогтоол, процессын протокол, хуралдааны тэмдэглэл болон тэдгээрийн хавсралт материал (схем, зураг, төлөвлөгөө, зураг төсөл) хамаарна (§71.1).

Бичгийн нотлох баримтыг эх хувиар нь эсхүл зохих ёсоор баталгаажуулсан хуулбарын хамт гаргана. Эх хувийг дараах тохиолдолд заавал гаргана (§71.2):

- хэргийн нөхцөл байдлыг зөвхөн эх хувиар баталгаажуулахыг хууль, эсхүл эрх зүйн бусад актаар шаардсан бол;
- хэргийн шийдвэрлэл нь эх хувийн баримтгүйгээр боломжгүй бол;
- шүүхэд ирүүлсэн хуулбаруудын агуулга хоорондоо зөрчилдөж байгаа бол.

Хэрэв бичгийн нотлох баримтын хуулбарыг шүүхэд цахим хэлбэрээр гаргасан бол, шүүх тухайн баримтын эх хувийг гаргуулах эрхтэй (§71.2). Хэргийн оролцогч этгээдээс шүүхэд гаргасан, эсхүл шүүхийн шаардлагын дагуу ирүүлсэн бичгийн нотлох баримтын хуулбарыг бусад оролцогч талуудад хүргүүлнэ (§71.3).

Биет нотлох баримт: Биет нотлох баримт гэж өөрийн гадаад төрх, шинж чанар, байршил болон бусад шинж тэмдгээрээ тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нөхцөл байдлыг тогтоох хэрэгсэл болохуйц эд зүйлсийг ойлгоно (§73).

Дуу болон дүрсний бичлэг: Электрон, эсхүл өөр төрлийн мэдээллийн төхөөрөмж дээр хадгалсан дуу, дүрс бичлэгийг гаргаж буй, эсхүл тэдгээрийг гаргуулж өгөхийг хүсэлтэд тусгаж буй этгээд тухайн бичлэг хэзээ, хэний санаачилгаар, ямар нөхцөлд хийгдсэн болохыг заавал мэдүүлэх үүрэгтэй (§77).

Шинжээчийн дүгнэлт: Хэргийн хэлэлцүүлгийн явцад шинжлэх ухаан, техник, урлаг, гар урлал болон бусад салбарын тусгай мэдлэг шаардагдах асуудал гарвал шүүх шинжилгээ (экспертиз) томилно. Шинжилгээг шүүхийн шинжээчийн байгууллага, тодорхой шинжээч эсхүл хэд хэдэн шинжээчид даалгаж болно (§79.1).

Хэргийн талууд болон бусад оролцогч этгээд шинжилгээний явцад шийдвэрлэгдэх шаардлагатай асуудлыг шүүхэд танилцуулах эрхтэй. Харин шинжээчийн дүгнэлт шаардлагатай асуудлын эцсийн хүрээг шүүх тогтооно. Шүүхээс санал болгосон асуултыг хүлээж аваагүй бол энэ тухайгаа үндэслэлтэй тайлбарлах үүрэгтэй. Талууд болон бусад оролцогч этгээд дараах эрхтэй (§79.2). Үүнд:

- шинжилгээг тодорхой шүүхийн шинжээчийн байгууллагад, эсхүл тодорхой шинжээчид даалгах хүсэлт гаргах;
- шинжээчид татгалзах үндэслэл мэдүүлэх;
- шинжээчид тавих асуултыг тодорхойлох;
- шинжилгээ томилсон шүүхийн тогтоол болон түүнд тусгагдсан асуултуудтай танилцах;
- шинжээчийн дүгнэлттэй танилцах;
- шүүхэд дахин, нэмэлт, иж бүрэн эсхүл комиссын шинжилгээ томилуулах хүсэлт гаргах.

Хэрэв тал шинжилгээнд оролцохоос зайлсхийж, шаардлагатай материал гаргаж өгөөгүйгээс шинжилгээ хийх боломжгүй бол, шүүх тухайн нөхцөл байдлыг тогтоогдсон эсхүл няцаагдсан гэж үзэж болно (§79.3).

Шүүх шинжээч томилох эсхүл татгалзах тухай тогтоол гаргана. Хэрэв шинжээч томилуулах хүсэлтийг талууд эсхүл бусад оролцогч гаргасан бол, зардлыг 96.1-д заасан дансанд урьдчилан төлсөн нөхцөлд шинжээч томилно. Энэ нь 96.2 ба 3-т заасан онцгой тохиолдолд хамаарахгүй бөгөөд ийм тохиолдолд зардлыг холбооны, эсхүл харьяалах субъектийн төсвөөс, эсхүл иргэний эд хөрөнгийн байдлыг харгалзан холбогдох төсвөөс нөхөн төлнө. Шүүхээс тогтоосон хугацаанд зардлыг байршуулж өгөөгүй бол хүсэлтийг татгалзах боломжтой. Гэвч хэргийн шийдвэрийг бусад нотлох баримтад тулгуурлан гаргах боломжгүй бол, шүүх өөрийн санаачилгаар шинжээч томилж болно (§79.4).

2.2.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

а) <u>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гэрчийн мэдүүлэг, шинжээчийн тайлан, мэргэжлийн дүгнэлт, баримт бичиг болон эд мөрийн баримт зэрэг нотлох баримтын төрлүүдийг тодорхойлон зохицуулсан байна. Дээрх нотлох баримтын төрлүүдийг авч үзье.

Гэрч: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (§48-71)-д гэрчтэй холбоотой харилцааг зохицуулж, гэрчийн төрлийг нарийвчлан зохицуулсан. Гэрч нь шүүхээс тогтоосон өдөр байцаалтад ирэх үүрэгтэй ба хуулиар зөвшөөрөгдсөн онцгой тохиолдлоос бусад үед гэрч мэдүүлэг өгөх үүрэгтэй (§48).

Хуульд гэрчийн төрлийг зохицуулсан бөгөөд дараах онцлог зохицуулалтууд байна. Үүнд:

- ердийн гэрч - шүүх дуудвал ирж мэдүүлэг өгөх үүрэгтэй, үндэслэлгүйгээр ирээгүй бол зардлыг төлүүлэх, торгууль, мөн албадан авчрах/албадан саатуулах арга хэмжээ авна (§51, §70);
- эмзэг гэрч - гэрч нь хохирогч бол, гэрчийн эрүүл мэндэд ноцтой хохирол учрах бодит аюул тулгарах боломжтой эсэх, гэрчийн хамгаалалт шаардлагатай эсэх, мөн гэрчийн хувийн амьдралтай холбоотой асуулт асуухаас зайлсхийх боломжтой эсэхийг шалгах ёстой (§48a);
- төрийн өндөр албан тушаалтнууд - Холбооны Ерөнхийлөгчийг өөрийн оршин суугаа газарт нь байцаана (§49). Парламентын гишүүдийг тэдгээрийн хуралдаж буй газарт нь, Засгийн газрын гишүүдийг тэдний албан өрөө, хэрэв албан өрөөндөө байхгүй бол тухайн байгаа газарт нь байцаана. Дээрх албан тушаалтнуудыг байцаахдаа тухайн байгууллагаас зөвшөөрөл авна (§50);
- төрийн албан хаагч - шүүгч, төрийн албан хаагч болон төрийн албанд ажиллагсад нь албаны нууц хадгалах үүрэгтэй бол гэрчийн мэдүүлэг өгөхдөө төрийн албаны тусгай зохицуулалтыг дагаж мөрдөнө (§54);
- мэргэшсэн гэрч - өнгөрсөн баримт, нөхцөл байдалд нотолгоо хэрэгтэй бөгөөд тусгай мэргэжлийн мэргэшсэн этгээдийг гэрчээр байцааж болох бөгөөд гэрчийн нотлох ажиллагааны журмыг баримтална (§85).

Хуулийн 52 дугаар зүйлд яллагдагчийн эхнэр/нөхөр (гэрлэлт цуцалсан байсан ч хамаарна), сүйт бүсгүй/залуу, хамтран амьдрагч (хамтын амьдрал дууссан байсан ч хамаарна), яллагдагчийн шууд болон хажуугийн төрөл садан (гуравдугаар үе хүртэл),

эсхүл хоёрдугаар үе хүртэл хамаатнаар дамжсан төрөл садан нь мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй бөгөөд татгалзаж буй үндэслэлээ хүсэлтээр баталгаажуулах ёстой.

Шинжээчийн тайлан: Хуулийн 7 дугаар хэсэг (Section VII, §72–85)-т шинжээчийн тайлантай холбоотой харилцааг зохицуулсан.

Шинжээч сонгох, шинжээчийн тоо, дүгнэлт гаргах хугацааг шүүгч тогтооно. Шинжээч нь гэрчийн адил шалтгаанаар дүгнэлт гаргахаас татгалзах эрхтэй (§76). Шинжээч ирэхээс татгалзсан, эсхүл хугацаа хэтрүүлсэн бол зардлыг нөхөн төлүүлж, захиргааны торгууль ногдуулна (§77). Шинжээч нь гэрч, эсхүл яллагдагчийг байцаах, хэргийн материалыг үзэх, байцаалтад оролцох, шууд асуулт тавих замаар дүгнэлтээ бэлтгэж болно.

Яллагдагчийн сэтгэцийн байдалд дүгнэлт гаргах шаардлагатай бол шүүх яллагдагчийг сэтгэцийн эмнэлэгт зургаан долоо хоногоос хэтрэхгүй хугацаанд ажиглалтад байлгах захирамж гаргаж болно (§77).

Мэргэжлийн дүгнэлт: Шүүх шинжилгээ, задлан, хяналт зэрэг ажиллагааг хуулийн 86-93 дугаар зүйлд зохицуулсан. Шүүх эмнэлгийн үзлэг, задлан шинжилгээ, булш малтах, нярай хүүхдийн задлан шинжилгээ, хордлогын химийн шинжилгээ, мөнгө болон албан ёсны тамга тэмдэг хуурамчаар үйлдсэн эсэх болон гарын үсгийн шинжилгээ хийлгэж, нотлох баримтаар ашиглана.

Баримт бичиг, эд мөрийн баримт: Хуулийн 249-256 дугаар зүйлд баримт бичиг болон бусад эд мөрийн баримтыг нотлох баримтаар ашиглахтай холбоотой харилцааг зохицуулсан. Шүүх хуралдаанд баримт бичиг (электрон баримт бичиг мөн адил)-ийг уншиж танилцуулах замаар нотлох ажиллагаанд ашиглана (§249). Дараах мэдүүлэг, дүгнэлт, баримт бичгийг шүүх дээр уншиж танилцуулж болно (§256). Үүнд:

- төрийн байгууллага, шүүхийн эмч, олон нийтийн журмаар тангараг өргөсөн шинжээчийн дүгнэлт;
- бие махбодын гэмтлийн талаарх эмнэлгийн магадлагаа;
- цусны сорьцын тайлан;
- жолоодлогын дэвтэр, цусны бүлэг, согтууруулах ундааны агууламжийн шинжилгээ;
- прокурорын байгууллагын мөрдөх ажиллагааны баримт бичиг (гэрчийн мэдүүлэг бус);
- файлд оруулсан хувиргалт, бичилт.

Хуулийн 250 дугаар зүйлд хүний хийсэн ажиглалтад үндэслэсэн бол түүнийг шүүх хуралдаанд шалгана, өмнөх мэдүүлгийг уншиж өгөх, мэдэгдлийг унших зэргээр орлуулж болохгүй гэж заасан. Хэрэв гэрч өмнөх шатанд мэдүүлэг өгсөн ч, шүүх хуралдаанд татгалзах эрхээ эдэлсэн бол түүний өмнөх мэдүүлгийг уншиж танилцуулж болохгүй (§252).

б) <u>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, баримт бичиг зэрэг нотлох баримтын төрлүүдийг тодорхойлон зохицуулсан байна. Дээрх нотлох баримтын төрлүүдийг авч үзье.

Гэрчийн мэдүүлэг: Хуулийн 373-401 дүгээр зүйлд гэрчтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан. Гэрчийн мэдүүлгийг нотлох баримтаар ашиглахдаа тухайн гэрчийн нэр, түүнийг ямар баримттай холбогдуулан байцаахыг тодорхой заах ёстой.

ХБНГУ-ын Ерөнхийлөгчийг түүний оршин суугаа байранд нь байцаах бөгөөд хэрэв мэдүүлэг нь Холбооны эсхүл тухайн муж улсын ашиг сонирхолд харшлах бол мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй. Шүүгч, төрийн албан хаагч болон нийтийн албанд ажиллаж буй бусад этгээдийг албаны нууцтай холбоотой асуудлаар байцаахад төрийн албаны тусгай журам үйлчилнэ. Мөн Бундастаг, мужийн парламент (Landtag), Холбооны Засгийн газар болон мужийн засгийн газрын гишүүд, түүнчлэн парламентын бүлгийн ажилтнуудад тусгай журам үйлчилдэг (§376).

Зохих ёсоор дуудагдсан гэрч ирээгүй тохиолдолд уг зардлыг гэрчээс гаргуулна. Мөн гэрчид торгууль ногдуулах, төлөх боломжгүй бол хорих ялаар шийтгэнэ (§380). Гэсэн хэдий ч гэрч ирэхгүй байх шалтгаанаа цаг тухайд нь хангалттай үндэслэлтэйгээр илэрхийлсэн бол хариуцлага хүлээхгүй. Дараах этгээд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй (§383). Үүнд:

- сүйт бүсгүй, эсхүл гэрлэлттэй адилтгах холбоо байгуулахаар амлалт өгсөн этгээд
- одоогийн, эсхүл хуучин эхнэр/нөхөр (хамт амьдарч байсан болон амьдарч байгаа хамтрагч);
- цусан төрөл, эсхүл хамаатан садны гуравдугаар үе хүртлэх шууд хамаарал бүхий, эсхүл хоёрдугаар үе хүртэлх хадам төрлийн хамаарал бүхий этгээд;
- шашны зүтгэлтэн;
- хэвлэл мэдээллийн ажилтан (сонин, радио, телевизийн нийтлэл, нэвтрүүлэг, эх сурвалжийн мэдээлэлтэй холбоотой мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй). Энэ нь нийтлэлийн редакцийн хэсэгт нийтлэгдсэн материалд хамаарна;
- Албан тушаал, мэргэжил, эсхүл нийгмийн байдал нь нууц хадгалах үүрэгтэй этгээдүүд нь хуульд заасан, эсхүл үүргийн шинж чанараар нууцлалыг шаарддаг тохиолдолд, мэдүүлэг нь тухайн нууц үүрэгт хамаарах баримт, нөхцөлтэй холбоотой байвал татгалзаж болно.

Гэрч нь дараах үндэслэлээр мэдүүлэг өгөхөөс татгалзаж болно (§384):

- хариулт нь гэрч, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээдийн эдийн засгийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй;
- мэдүүлэг нь нэр төрийг гутаах, эсхүл эрүү, захиргааны зөрчлийн хэрэг үүсгэх эрсдэлтэй;
- техникийн болон худалдааны нууцыг задруулахгүйгээр хариулах боломжгүй асуултуудын талаар.

Гэрч нь дараах тохиолдолд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзаж болохгүй. Үүнд:

- гэрч нь хэргийн талуудын хоорондын эрх зүйн хэлцэл болон түүний биелэлттэй холбоотой асуудлаар оролцсон бол;
- гэр бүлийн хүрээний төрсөн, гэрлэлт, нас баралттай холбоотой баримт, нөхцөл байдлын талаар;
- гэр бүлийн өмчийн харилцаанд холбогдох баримт, нөхцөл байдлын талаар;
- маргаантай эрх зүйн харилцааны хүрээнд, гэрч нь тухайн талын өмнөх өмчлөгч эсхүл төлөөлөгчийн хувьд үйлдсэн гэж үзэж буй үйлдэл, нөхцөл байдалтай холбоотой асуудлаар.

Шашны зүтгэлтэн болон нууц хадгалах үүрэгтэй мэргэжилтэн нь нууц хадгалах үүргээс албан ёсоор чөлөөлөгдсөн тохиолдолд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхгүй байна. Гэрч нь мэдүүлэг өгөхөөс өмнө тангараг өргөнө.

Шинжээчийн дүгнэлт: Хуулийн 402-414 дүгээр зүйлд шинжээчийг томилох, түүний үүрэг, тайлан гаргах, тайлан гаргахаас татгалзах эрхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Шүүх шинжээчийг сонгож, тоог тогтоон, шинжээчийн үйл ажиллагааны хүрээг тодорхой зааварчилгаагаар тогтоож өгч болно.

Шинжээч нь шүүхээс түүнд тогтоосон даалгавар нь түүний мэргэжлийн хүрээнд хамаарах эсэх, нэмэлт шинжээч татан оролцуулалгүйгээр гүйцэтгэх боломжтой эсэхийг нэн даруй шалгаж, хэрэв боломжгүй бол нэн даруй мэдэгдэх ёстой. Шүүхийн шаардлагаар шинжээч хэрэглэсэн материал, судалгааны үр дүнг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд биелүүлээгүй тохиолдолд шүүх захирамж гаргана.

Хэрэв шүүх шинжээчийн тайланг бичгээр ирүүлэхийг шаардсан бол тогтоосон хугацаанд гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.

Баримт бичиг: Хуулийн 415-444 дүгээр зүйлд баримт бичигтэй холбоотой харилцааг зохицуулсан. Төрийн буюу албан ёсны баримт бичигт тусгагдсан мэдүүлэг, үйлдлийг нотлох баримтаар зөвшөөрнө. Гэхдээ тухайн баримт бичиг буруу үйлдэгдсэн болохыг нотолж эсрэг нотолгоо гаргаж болно. Дараах баримт бичгийг нотлох баримтаар хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хувийн тэмдэглэл, баримт бичигт тэдгээрийг олгосон талуудын гарын үсэгтэй бол, эсхүл нотариатаар баталгаажуулсан бол;
- Төрийн болон албан ёсны цахим баримт бичгийн баталгаат хэвлэмэл хуудас;
- Төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан захирамж, шийдвэрийг агуулсан нийтийн бүртгэл, баримт бичиг.

Шүүх нь баримт бичгийг хассан, устгасан, хавсаргасан болон бусад гадны согог дутагдлыг харгалзан нотлох хүчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох, бууруулах эсэхийг өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ.

Мөн хэргийн нөхцөл байдалд үндэслэн гадаадын төрийн байгууллага, эсхүл олон нийтийн итгэлийг хүлээсэн гадаадын иргэн, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн гэх тэмдэглэл, баримт бичгийг нэмэлт нотолгоогүйгээр үнэн зөв гэж үзэх эсэхийг шүүх өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ. Холбооны Бүгд Найрамдах Улсын консул эсхүл сайдын хууль ёсны зөвшөөрөл нь тухайн баримт бичгийн үнэн зөвийг нотлоход хангалттайд тооцогдоно (§438).

Тэмдэглэл, баримт бичгийн үнэн зөв эсэхийг гар бичмэлийн харьцуулалтаар тогтоож болно (§441).

Хэрэв талуудын нэг нь бичлэг, баримт бичгийг устгасан буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд нөгөө талын гаргасан мэдэгдлийг үнэн зөв гэж үзэх үндэслэлтэй (§444).

ГУРАВ. НОТЛОХ БАРИМТ ЦУГЛУУЛАХ ЖУРАМ

3.1.Австралийн Холбооны Улс

Нотлох баримтын тухай хуулиар нотлох баримтын төрөл, хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл, нотолгооны стандарт, нотлох баримтыг хүлээн авах зэрэг харилцааг зохицуулсан бөгөөд нотлох баримтыг цуглуулах ажиллагааг зохицуулаагүй.

3.2.Америкийн Нэгдсэн Улс

Нотлох баримтын Холбооны дүрмээр нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдал, хамаарал, жинхэнэ эсэхийг баталгаажуулах зэргийг зохицуулсан бөгөөд нотлох баримт цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулаагүй.

3.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:

Хуулийн 308-2 дугаар зүйлд хууль бусаар олж авсан буюу зохих журмын дагуу цуглуулаагүй нотлох баримтыг хүлээн авахгүй байх зарчмыг баримтална. Өөрөөр хэлбэл, журам, хууль ёсны ажиллагааг зөрчиж олж авсан аливаа нотлох баримтыг хүлээн авахгүй.

Хуулийн 215 дугаар зүйлд зааснаар мөрдөгч болон прокурор нь мөрдөн шалгах ажиллагааны явцад шүүгч, прокурорын зөвшөөрлөөр хураан авах, нэгжих, үзлэг хийнэ. Харин 216 дугаар зүйлд зааснаар прокурор, шүүх, эсхүл цагдаагийн албан хаагч яаралтай/зайлшгүй тохиолдолд сэжигтнийг баривчлах, цагдан хорихдоо зөвшөөрөл авахгүй. Үүнд:

- сэжигтнийг бусдын байр, тээврийн хэрэгсэл зэрэгт шалгах;
- баривчилсан газар дээр нь хураах, нэгжих, үзлэг хийхийг зөвшөөрнө.

Гэмт хэрэг үйлдсэн газар дээр зөвшөөрөл авах боломжгүй яаралтай нөхцөлд шууд ажиллагаа хийж болох бөгөөд дараа нь нэн даруй зөвшөөрөл авах ёстой. Хуулийн 217 дугаар зүйлд баривчлагдсан этгээдийн эзэмшиж, хадгалж байсан эд зүйлийг нэн даруй хураан авах шаардлагатай бол 24 цагийн дотор хураан авах, нэгжих, үзлэг хийж болох бөгөөд 48 цагийн дотор зөвшөөрлийн хүсэлт гаргана. Хэрэв энэ хугацаанд зөвшөөрөл аваагүй бол хураан авсан эд зүйлийг нэн даруй буцааж өгнө.

Хуулийн 218 дугаар зүйлд зааснаар сэжигтэн, эсхүл бусад этгээдийн сайн дураар гаргаж өгсөн, хаягдсан эд зүйлсийг зөвшөөрөлгүйгээр хураан авч болно.

3.4.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Эрүүгийн шударга ёсны тухай болон Иргэний нотлох баримтын тухай хуулиар нотлох баримтын төрөл, хүлээн зөвшөөрөгдөх байдал болон шүүхийн журмыг зохицуулсан бөгөөд нотлох баримт цуглуулах ажиллагааг Цагдаа болон эрүүгийн нотлох

баримтын тухай хууль (Police and Criminal Evidence Act, 1984)-аар зохицуулдаг. Цагдаа болон эрүүгийн нотлох баримтын тухай хуулиар нотолгооны стандарт, журмуудыг заасан (Б.Батзориг, Б.Эрдэнэбат, Ц.Шийтэрчулуун, 2021, хууд. 44).

3.5.Канад Улс

Нотлох баримтын тухай хууль нь нотлох баримтын хэлбэр, төрөл, давуу эрхийн талаар зохицуулж, баримт цуглуулах ажиллагааг энэ хуулиар зохицуулаагүй. Нотлох баримт цуглуулах ажиллагаанд Канадын эрх, эрх чөлөөний бүлэг (Канадын Үндсэн хуулийн нэмэлт)-ийн 8 болон 24 дүгээр зүйл[17] болон шүүхийн жишгийг баримталдаг.

3.6.Оросын Холбооны Улс

а) <u>Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуулийн 86 дугаар зүйлд нотлох баримт цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулна. Энэ зүйлд зааснаар нотлох баримтыг цуглуулах ажиллагааг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүх нь энэ хуульд заасан мөрдөн шалгах болон бусад процессын ажиллагаа явуулах замаар хэрэгжүүлнэ (§86.1).

Сэжигтэн, яллагдагч, түүнчлэн хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч болон тэдгээрийн төлөөлөгчид бичгийн баримт болон эд зүйлийг цуглуулж, тэдгээрийг эрүүгийн хэрэгт нотлох баримт болгон хавсаргуулах эрхтэй (§86.2).

Өмгөөлөгч нотлох баримтыг дараах хэлбэрээр цуглуулж болно (§86.3). Үүнд:

- эд зүйл, баримт бичиг болон бусад мэдээллийг хүлээн авах;
- этгээдийг тэдний зөвшөөрөлтэйгөөр асууж тодруулах;
- төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага болон бусад байгууллагаас тодорхойлолт, шинж чанарын тодорхойлолт болон бусад баримт бичгийг гаргуулан авах. Эдгээр байгууллагууд нь хүсэлтээр гаргуулсан баримт бичгийг буюу тэдгээрийн хуулбарыг заавал гаргаж өгөх үүрэгтэй.

б) <u>Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуулийн 57 дугаар зүйлд нотлох баримтыг хэрхэн гаргах, мөн шүүхийн журмаар гаргуулахтай холбоотой дараах зохицуулалтыг тогтоосон.

Нотлох баримтыг гаргах: Хэрэгт оролцогч этгээдүүд нотлох баримтыг шүүхэд өөрсдөө гаргана. Хэрэв тухайн баримт бусад оролцогчид байхгүй бол хуулбарыг тэдэнд илгээх буюу гардуулна. Энэ нь баримтыг цахим хэлбэрээр гаргасан тохиолдолд ч хамаарна (§57.1).

---

[17] Section 8: Хайлт, хураалт (search and seizure)-аас хамгаалах үндсэн эрх-хэрвээ “үндэслэлгүй” хайлт/хураан авах ажиллагаа явуулж олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд хасах үндэслэл болдог. Section **24(2)**: Хэрвээ тухайн баримт олж авахдаа хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчсөн бол, шүүх “олох хэлбэр, нөхцөл, үнэлэлт”-ийг харгалзан түүнийг **хасах (exclude)** эсэхийг шийддэг эрхтэй.
Хандах: https://www.canada.ca/en/canadian-heritage/services/how-rights-protected/guide-canadian-charter-rights-freedoms.html

Шүүхийн дэмжлэг: Шүүх оролцогч этгээдүүдэд нэмэлт баримт гаргахыг санал болгож болох бөгөөд хэрэв баримт гаргах нь хүндрэлтэй бол шүүхийн дэмжлэгээр цуглуулах, гаргуулах боломжтой (§57.2).

Гаргуулах хүсэлтийн шаардлага: Нотлох баримт гаргуулах тухай хүсэлтэд тухайн баримтын нэр, батлах эсхүл няцаах нөхцөл байдал, гаргаж чадахгүй байгаа шалтгаан болон байршлыг тодорхой заана. Шүүх энэ үндсэн дээр талд заавал биелүүлэх хүсэлт олгох эсхүл баримтыг өөрөө гаргуулна. Баримт эзэмшигч этгээд түүнийг шууд шүүхэд илгээх буюу хүсэлт бүхий этгээдэд гардуулна (§57.3).

Хугацаанд гаргаж өгөх боломжгүй тохиолдол: Албан тушаалтан эсхүл иргэн баримтыг бүрэн эсхүл хугацаанд гаргаж өгөх боломжгүй бол, тав хоногийн дотор шалтгааныг тодорхой дурдан шүүхэд мэдэгдэх үүрэгтэй (§57.4).

Шүүхийн торгууль: Хэрэв мэдэгдээгүй, эсхүл шүүхийн шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол буруутай этгээдэд энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан журмаар шүүхийн торгууль ногдуулна (§57.5).

Үүргээс чөлөөлөхгүй: Шүүхийн торгууль ногдуулах нь тухайн албан тушаалтан эсхүл иргэнийг баримтыг шүүхэд гаргаж өгөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй (§57.6).

3.7.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

а) <u>Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Нотлох баримт цуглуулах ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчлан заагдсан бөгөөд дараах үндсэн журмыг баримтална. Үүнд:

Мөрдөн шалгах ажиллагаа: Цагдаа болон прокурорын байгууллага Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баримт цуглуулна.

- хураан авах, нэгжлэг хийх (§94-98);
- биед үзлэг хийх (§81a-81h);
- байцаалт авах (§161a, 163);
- нууц мөрдлөг, сонсгол (§100a-100f).

Шүүхийн шатны нотлох ажиллагаа: Хуулийн 244 дүгээр зүйлд зааснаар шүүх нотлох ажиллагааг удирдан явуулна. Шинжээч, гэрч, бичиг баримтаар нотлох баримт авах хүсэлтийг шүүх шаардлагагүй гэж үзвэл татгалзаж болно.

Хураан авах: Хуулийн 98 дугаар зүйлд эд зүйл хураан авах ажиллагааг шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх бөгөөд яаралтай нөхцөлд прокурор болон мөрдөн шалгах байгууллагын ажилтнууд гүйцэтгэж болно. Хэрэв шүүхийн шийдвэргүйгээр хураан авах ажиллагаа хийсэн бол 3 хоногийн дотор шүүхээр баталгаажуулах ёстой бөгөөд шүүхийн шийдвэр гаргуулах хүсэлтийг холбогдох этгээд өөрөө ч гаргаж болно.

Харилцаа холбоог хянах, баталгаажуулж авах: Тус хуулийн 100a дугаар зүйлд харилцаа холбоог хянахтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд шүүхийн шийдвэрээр холбогдох этгээдэд мэдэгдэлгүйгээр дараах тохиолдолд[18] харилцаа холбооны мэдээллийг бичиж авах боломжтой. Үүнд:

[18] 100a.2. Энэхүү арга хэмжээг зөвхөн Эрүүгийн хууль болон тусгай хуулиудад заасан тодорхой хүнд гэмт хэрэгт (төрийн эсрэг гэмт хэрэг, авлига, үндэсний аюулгүй байдалд халдах, терроризм, хүн худалдаалах,

- тодорхой баримтаар тухайн этгээд нь хүнд гэмт хэрэг үйлдсэн, завдсан, эсхүл өөр гэмт хэрэг үйлдэх замаар бэлтгэсэн гэж үзэх үндэслэл байвал;
- онц ноцтой гэмт хэрэг гэж тооцогдовол;
- үнэн мөнийг тогтоох бусад арга хэрэгсэл үр дүнгүй үзвэл.

Шаардлагатай тохиолдолд техник хэрэгсэл ашиглан тухайн этгээдийн мэдээллийн технологийн системд нэвтрэн, шифрлэлгүй мэдээллийг хянана.

б) <u>Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Иргэний нотлох баримт цуглуулах ажиллагаа нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нарийвчлан заагдсан бөгөөд дараах үндсэн журмыг баримтална. Үүнд:

Нотлох баримт авах (Taking of evidence)**:** Хуулийн 284 дүгээр зүйлд шүүх нь талуудын зөвшөөрлийг авсан тохиолдолд, нотлох баримт авах ажиллагааг өөрийн үзэмжээр зохистой гэж үзсэн аргаар явуулж болох бөгөөд энэ талаар талуудаас урьдчилан зөвшөөрөл авна. Шүүх хэргийг хэлэлцэхээс өмнө нотлох баримтыг авна. Зөвхөн энэ хуульд заасан тохиолдолд нотлох баримт цуглуулахыг тухайн хэргийг хянан хэлэлцэж буй шүүхийн гишүүн эсвэл өөр шүүхэд шилжүүлнэ.

Нотлох баримт гаргах хугацаа (§356): Хэрэв ямар нэг саад бэрхшээлээс шалтгаалан нотлох ажиллагааг явуулах боломжгүй болж, энэхүү байдал хэр хугацаанд үргэлжлэх нь тодорхойгүй бол шүүх тодорхой хугацаа тогтоох тухай захирамж гаргана.

Талууд нотлох ажиллагаанд оролцох (§357): Талууд нотлох ажиллагаанд оролцох эрхтэй. Хэрэв нотлох ажиллагааг хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийн нэг гишүүнд, эсхүл өөр шүүхэд даалгасан бол, уг нотлох ажиллагааны товыг шүүх энгийн захидлаар талуудад мэдэгдэнэ. Харин шүүх онцгойлон “хууль ёсны мэдэгдэх ажиллагаагаар” хүргэхийг шаардсан бол түүнийг дагаж мөрдөнө. Энгийн шуудангаар илгээсэн мэдэгдэл дараах байдлаар хүчинтэйд тооцогдоно:

- хэрэв хүлээн авагч тухайн шуудангийн хүрээний дотор оршин суудаг бол дараагийн ажлын өдөрт**,**
- бусад тохиолдолд шуудан илгээснээс хойш хоёр дахь ажлын өдөрт хүргэгдсэн гэж үзнэ.

Гэхдээ тал нь мэдэгдлийг хүлээн аваагүй, эсвэл хожуу хүлээн авсан гэдгээ хангалттай нотолж чадвал энэ хугацааг баримтлахгүй.

Шүүхийн захирамж гаргах (§358): Хэрэв нотлох ажиллагаа тусдаа журмаар явагдах шаардлагатай бол шүүх нотлох баримт авах тухай захирамж гаргана. Шүүх аман маргаан (oral argument)-ыг эхлэхээс өмнө нотлох баримтыг гаргаж болно.

Гадаад улсаас нотлох баримт авах (§363-364): хэрэв нотлох баримтыг гадаад улсаас авчрах тохиолдолд даргалагч нь холбогдох төрийн байгууллагад хүсэлт гаргана. Хэрэв уг ажиллагааг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Консул гүйцэтгэх боломжтой бол хүсэлтийг түүнд илгээнэ.

Гадаадын төрийн эрх бүхий байгууллагаас нотлох баримт авахыг хүссэн тохиолдолд шүүх нотлох баримтыг хүссэн талд хүсэлтийн бичгийг бэлтгэн илгээх, уг хүсэлтийг хэрэгжүүлэхийг шаардаж болно. Түүнчлэн шүүх нь мөн талд гадаад улсын

авлигын ноцтой хэлбэрүүд, хар тамхи, зэвсгийн хууль бус худалдаа, дайнтай холбоотой гэмт хэрэг гэх мэт) хэрэглэхийг зөвшөөрнө.

хуулийн дагуу үйлдсэн төрийн баримт бичгийг гаргаж өгөхийг даалгаж болох бөгөөд уг баримт бичиг нь тухайн улсын хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Дээрх 2 тохиолдолд нотлох ажиллагааны захирамжид, уг баримт бичгийг шүүхэд хүргүүлэх хугацааг тодорхой заах бөгөөд тогтоосон хугацаанд өгөөгүй бол шүүх өөрийн үзэмжээр нотлох баримтыг хэрэглэх эсэхийг шийдвэрлэнэ.

Дуу, дүрсний дамжуулалт (§128a): Шүүх нь талууд, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон зөвлөхүүд хүсэлт гаргасан тохиолдолд эсхүүл өөрийн санаачлагаар аман хэлэлцүүлэг, гэрч, шинжээчийн байцаалт болон талуудыг өөр байршилд байж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг зөвшөөрч болох бөгөөд шүүх хуралдааны дуу, дүрсийг бодит хугацаанд тухайн байршил болон шүүхийн танхимд зэрэг дамжуулна. Гэхдээ энэ тохиолдолд дамжуулалтын бичлэг хийхгүй.

ДӨРӨВ. НОТЛОХ БАРИМТЫН ЗӨВШӨӨРӨГДӨХ НӨХЦӨЛ

4.1.Австралийн Холбооны Улс

Нотлох баримтын тухай хуулийн 3 дугаар бүлэгт нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлийг тогтоосон. Тухайлбал:

- хамааралтай байдал: Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралтай нотлох баримтыг хүлээн авч, хамааралгүй нотлох баримтыг хүлээн авахгүй. Хамааралтай нотлох баримт гэж тухайн баримтыг хүлээн зөвшөөрснөөр маргаантай баримтын үнэн эсэх магадлалыг шууд буюу шууд бусаар өөрчлөх чадвартай баримтыг хэлнэ. Хамааралтай нотлох баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүлээн зөвшөөрнө. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралгүй нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй (§56);
- жинхэнэ байдал, холбоо хамаарал: Нотолгоо нь баримт бичиг, эд зүйл зэрэг материаллаг эх сурвалжтай бол шүүх түүний жинхэнэ эсэх, холбоо, хамаарлыг харгалзан үнэлж болно[19]. Хэрэв нотлох баримтын хамаарал нь шүүхийн өөр дүгнэлтээс (жишээ нь: уг баримт тухайн талын хэлж буй баримт мөн эсэх) хамаарч байвал шүүх үндэслэлтэй гэж үзвэл түр хугацаагаар хамааралтай гэж үзэж болно (§58);
- санал бодлын нотолгоо: Бодит баримтаас бусад зүйлийн талаарх санал бодлыг нотлох баримтаар ашиглахыг хориглох бөгөөд зөвхөн мэргэшсэн этгээдийн санал бодлыг нотолгоонд ашиглаж болно (§76-80);
- өмнөх шийдвэрийн хэрэглээ: Өмнөх шүүхийн шийдвэрийг дахин нотолгоо болгон ашиглахыг хориглох бөгөөд зарим тохиолдолд (жишээлбэл, ял шийтгэгдсэн тухай баримт) хэрэглэж болно (§91-94);
- дан нотолгоо: Гагцхүү гэрчийн үнэнч байдалд хамаарах дан нотолгоог хязгаарлана (§102);
- зан төлөвийн нотолгоо: Зан төлөвийн нотолгоог зарим тохиолдолд шүүхийн зөвшөөрөлтэйгээр, эсхүл хуульд заасан хүрээнд ашиглана (Part 3.8, s. 109–112);

[19] Австрали. Нотлох баримтын тухай хуулийн 3.1 дэх хэсгийн §58

- шүүхийн үзэмжээр хасах: Шударга бус байдал үүсгэх, талуудыг төөрөгдүүлэх, цаг хугацаа зохисгүй үрэх эрсдэлтэй, эсхүл хууль бусаар авсан нотлох баримтыг хүлээн авахгүй (§135-139).

Хуулийн 138 дугаар зүйлд зохисгүй, эсхүл хууль бусаар олсон нотлох баримтыг шүүхийн үзэмжээр хүлээн авах, эсхүл хасах шалгуурын талаар зохицуулсан. Тухайлбал, зохисгүйгээр[20], эсхүл Австрали Улсын хууль тогтоомж зөрчиж олж авсан, эсхүл түүний үр дагаварт нь олж авсан нотлох баримтыг шүүх хүлээн авахгүй. Энэ үед шүүх дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- нотолгооны үнэ цэнэ;
- ач холбогдол;
- гэмт хэргийн шинж чанар, үйлдэл, өмгөөллийн шалтгаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны субьектийн байдал;
- зөрчлийн ноцтой байдал;
- санаатай эсвэл болгоомжгүй эсэх;
- зөрчил нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхэд харшлах эсвэл зөрчилдөх эсэх;
- холбогдох өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (шүүхийн шатанд байгаа эсэхээс үл хамааран) явагдсан эсэх;
- хууль зөрчихгүйгээр ижил нотлох баримтыг олох боломж, бэрхшээл.

Тус хууль нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэхэд хэрэглэгдэх нотлох баримтын стандартыг тодорхой заасан. Энэхүү зохицуулалт нь иргэний хэрэг, эрүүгийн хэрэг болон нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой асуудлуудад ялгаатай байдлаар үйлчилдэг.

Иргэний хэрэг дэх нотлох стандарт: Хуулийн 140 дүгээр зүйлд зааснаар, иргэний хэрэгт шүүх нь тухайн талын нэхэмжлэл, эсхүл хамгаалалтыг “магадлалуудын тэнцвэрийн зарчим” (balance of probabilities)-аар үнэлж, хэрэв уг шалгуур хангагдсан гэж үзвэл нотлогдсон гэж дүгнэнэ. Шүүх энэ үнэлэлтдээ:

- нэхэмжлэл, эсхүл хамгаалалтын шинж чанар;
- маргааны агуулга;
- мэдүүлгийн ноцтой байдлыг харгалзан үзэхээр заасан.

Эрүүгийн хэрэг дэх нотлох стандарт: Хуулийн 141 дүгээр зүйл нь эрүүгийн хэрэгт яллагч талын (прокурорын) нотолж буй асуудлыг “эргэлзээгүйгээр” (beyond reasonable doubt) нотлогдсон гэдэгт шүүх бүрэн итгэсэн тохиолдолд л хүлээн зөвшөөрнө. Харин яллагдагчийн нотолж буй асуудлыг “магадлалуудын тэнцвэрийн зарчим”-аар үнэлнэ.

Нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх стандарт: Хуулийн 142 дугаар зүйлд нотлох баримтыг хүлээн авах эсэхийг шийдвэрлэхдээ шүүх мөн “магадлалуудын тэнцвэрийн

[20] Нотлох баримтын тухай хуулийн 138(2) 1)-ийг хязгаарлахгүйгээр, байцаалтын үед, эсхүл байцаалтын үр дүнд хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг болон түүнээс улбаалан олсон нотлох баримтыг зохисгүйгээр олсон гэж үзнэ. Хэрэв байцаалт явуулсан этгээд:
(а) байцаалтын явцад тухайн этгээд байцаалтын асуултад үндэсдэдтэй, ухамсартайгаар хариуцлах чадварыг нь ноцтойгоор сулруулах магадлалтай үйлдлийг хийсэн, эсхүл хийх ёстой үйлдлийг санаатайгаар орхигдуулсан байвал;
(б) байцаалтын явцад худал мэдүүлэг өгсөн, эсхүл мэдэх боломжтой байсан ч тухайн худал мэдүүлэг нь байцаагдаж буй этгээдийг хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг өгөхөд хүргэх магадлалтай байсан бол.

зарчмыг” баримтална. Энэ тохиолдолд шүүх нотлох баримтын ач холбогдол болон холбогдох мэдүүлгийн ноцтой байдлыг заавал харгалзан үзнэ.

4.2.Америкийн Нэгдсэн Улс

Нотлох баримтын холбооны дүрмийн 401 дүгээр зүйлд зааснаар ямар нэг үйл баримтыг нотлохгүй байсан үеийнхтэй харьцуулахад, тухайн үйл баримтыг илүү, эсхүл бага магадлалтай болгодог, мөн тухайн хэрэгт ач холбогдолтой бол хамааралтай гэж үзнэ. Хамааралтай нотлох баримтыг АНУ-ын Үндсэн хууль, холбогдох холбооны хууль, Нотлох баримтын дүрэм болон Дээд шүүхээс баталсан бусад дүрэмд өөрөөр заагаагүй бол хүлээн зөвшөөрнө. Харин хамааралгүй нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй. Шүүх нь нотлох баримтын нотлох чадварыг харгалзан хасч болно (§403).

Эвлэрэл, тохиролцох хэлэлцээ (§408): Маргаантай нэхэмжлэлийн үндэслэл, хэмжээг нотлох/няцаах зорилгоор эвлэрэх, тохиролцохтой холбоотой санал, амлалт, хэлэлцээний үеийн үйлдэл/мэдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй.

Эмнэлгийн болон түүнтэй адилтгах зардлыг төлнө гэж амласан, санал болгосон нотлох баримтууд нь гэмтлийн хариуцлага нотлоход зөвшөөрөгдөхгүй (§409).

Бэлгийн шинжтэй гэмт хэрэг үйлдсэн гэх иргэний болон эрүүгийн хэрэгт дараах төрлийн нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй (§412). Үүнд:

- хохирогч бусадтай бэлгийн харьцаанд орсон болохыг нотлох баримт;
- хохирогчийн бэлгийн дур хүслийг нотлох нотлох баримтууд.

Эх хувийн дүрэм ба хуулбар: Баримт бичгийн хуулбарыг эх хувьтай адил хэмжээгээр зөвшөөрөх бөгөөд эх хувь шаардлагагүй, бичвэр, бичлэг, гэрэл зургийн агуулгын бусад нотлох баримтыг зөвшөөрнө (§1004). Үүнд:

- бүх эх хувь нь алдагдах буюу устгагдсан, энэ нь нотолгоо гаргаж буй тал санаатай үйлдлээс үүдээгүй байх;
- эх хувийг аль ч шүүхийн журмаар авах боломжгүй;
- эх хувийг санал болгох тал нь эх хувийг хянаж байсан бөгөөд
- шүүхийн нэхэмжлэл, өргөдөл, эсхүл бусад аргаар тухайн эх хувь шүүх хуралдаанд нотлох баримт болох талаар мэдэгдэл авсан боловч тухайн хуралдаанд эх хувийг гаргаж өгөөгүй байх;
- тухайн бичвэр, бичлэг, гэрэл зураг нь асуудалтай нягт холбоотой байх.

Нотлох баримт болгон зөвшөөрөгдөх их хэмжээний материалыг шүүхэд танилцуулсан эсэхээс үл хамааран шүүх хуралдаанд хялбархан судлах боломжгүй их хэмжээний бичвэр, бичлэг, гэрэл зургийн агуулгыг нотлохын тулд санал болгосон хураангуй, график, тооцоог нотлох баримт болгон хүлээн зөвшөөрч болно.

4.3.Бүгд Найрамдах Солонгос Улс

а) <u>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуулийн 3 дугаар бүлгийн II дугаар хэсэг (Section 2)-т нотлох баримтын зөвшөөрөгдөх нөхцөлтэй холбоотой харилцааг зохицуулсан. Хуулийн 307-310 дугаар зүйлд нотлох баримтын зарчмыг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд:

- нотолгоонд тулгуурлан яллах (§307.1): Үйл баримтыг нотлох баримтад үндэслэн тогтооно;
- стандарт (§307.2): Эрүүгийн гэм буруутай үйл баримтыг “зохистой эргэлзээ үлдэхгүй (no reasonable doubt)” түвшинд тогтооно;
- чөлөөтэй үнэлэх зарчим (§308): Нотлох баримтыг шүүгч өөрийн дотоод итгэл үнэмшлээр үнэлнэ;
- хууль бус нотолгоо (§308): Шаардлагатай журам, хууль ёсны ажиллагааг зөрчиж олж авсан аливаа нотлох баримтыг зөвшөөрөхгүй;
- албадлага, эрүү шүүлт (§309): Эрүүдэн шүүх, хүчирхийлэх, заналхийлэл, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх гэх мэт сайн дурын бус мэдүүлэг авсан бол хүлээн зөвшөөрөхгүй;
- нэг л мэдүүлэгт тулгуурлахыг хориглох (§310): Шүүгдэгчийн мэдүүлэг нь түүний эсрэг цорын ганц нотолгоо байвал гэм бурууг тогтоосонд тооцохгүй.

Нотлох баримт нь дараах шаардлагыг хангасан бол нотолгооны чадвартай гэж үзнэ. Үүнд:

- дам мэдүүлэг (hearsay) буюу шүүхийн гадна өгсөн мэдүүлгийг ердийн нөхцөлд ашиглахгүй бөгөөд хуульд заасан тусгай хүрээнд зөвшөөрнө (§310-2);
- шүүх, прокурор, шүүхийн цагдаагийн үйлдсэн тэмдэглэл, шинжээчийн дүгнэлт зэргийг тодорхой нөхцөлтэйгөөр хэрэглэж болно (§311-313);
- мэдүүлэг өгөгч нас барсан, өвчтэй, эсхүл оршин суугаа газар нь тодорхойгүй бол онцгой нөхцөлөөр хэрэглэнэ (§314);
- шууд хүчинтэй баримт бичиг (гэр бүлийн бүртгэл, нотариатын бичиг, тогтмол хөтлөгдсөн санхүүгийн бүртгэл гэх мэт) бол шууд нотлох баримт болно (§315);
- шүүгдэгч болон бусад этгээдийн мэдүүлэг зөвхөн сайн дурын үндсэн дээр өгөгдсөн тохиолдолд хэрэглэнэ (§316-317).
- улсын яллагч, шүүгдэгч хоёрын зөвшөөрсөн нотлох баримтыг жинхэнэ болох нь тогтоогдсон бол шууд хэрэглэнэ (§318).

Хуулийн 318-2 дахь хэсэгт нотлох баримтын зөвшөөрөгдөх байдлыг няцаахад зориулсан нотлох баримтын талаар зохицуулсан. Тухайлбал, хуулийн 213-316 дугаар зүйлд зааснаар анхнаасаа нотлох баримт болгон ашиглагдахгүй баримт бичиг, мэдүүлгийг шүүгдэгч болон бусад этгээдийн мэдүүлгийн зөвшөөрөгдөх байдлыг няцаах зорилгоор шүүх хуралдаан, эсхүл урьдчилсан хэлэлцүүлэгт гаргаж ашиглаж болно. Дүрс бичлэгийг зөвхөн тухайн этгээдийн ой санамжийг сэргээхэд зайлшгүй шаардлагатай тохиолдолд үзүүлнэ гэж заасан.

б) <u>Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуульд шүүх нь нэхэмжлэлд дурдсан нотлох баримт үнэн эсэхийг бүхэлд нь заргын агуулга болон нотлох баримтын шинжилгээний дүнг харгалзан нийгмийн шударга ёс, тэгш байдлын үзэл санаанд нийцүүлэн, логик ба туршлагын зарчмаар дотоод итгэл үнэмшлээр үнэлнэ гэж заасан.

4.4.Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

<u>Эрүүгийн шударга ёсны тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуульд нотлох баримт нь найдвартай байдлыг алдагдуулсан, гадны нөлөө орсон, хууль бусаар өөрчлөгдсөн, эсхүл зохиомлоор бий болсон бол түүнийг хууль зөрчсөн нотлох баримт (Contaminated evidence (§107)) гэж үзнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдэгдэл нь шүүхийн ажиллагаанд амаар өгсөн мэдүүлэг бус, тухайн мэдэгдлийг хүлээн авах нь цаг үрэх (undue waste of time) эрсдэл дагуулах бол шүүх хүлээн авахаас татгалзаж болно (§126).

Мөн яллагдагчийн муу зан чанарыг нотлох нотолгоог дараах тохиолдолд зөвшөөрнө (§100). Үүнд:

- хэрэгт оролцогч талууд уг нотлох баримтыг зөвшөөрөхөөр тохиролцсон;
- яллагдагч өөрөө гаргасан, эсхүл эсрэг талаас байцаалт авах (cross-examination)-үед илэрсэн;
- чухал тайлбарлах ач холбогдолтой байх;
- талуудын маргаантай чухал асуудалд хамаарах;
- талуудын хоорондын маргаанд чухал ач холбогдолтой бол;
- яллагдагчаас үүсгэсэн хуурамч сэтгэгдлийг засах зорилготой байх;
- яллагдагч өөр этгээдийн зан чанарт халдсан.

Найдвартай байдал (Credibility): Дам мэдүүлэг/мэдэгдлийг зөвшөөрсөн ч уг этгээд амаар мэдүүлээгүй бол, гэрчийн найдвартай байдлыг шалгахад:

- гэрчээр мэдүүлэг өгсөн бол найдвартай байдалтай холбоотойгоор зөвшөөрөгдөх байсан аливаа нотолгоог зөвшөөрнө;
- шүүхийн зөвшөөрлөөр зөрөг асуултаар тавих боломжтой байсан зарим асуудлыг өөрөөр нотолж болно;
- өмнөх болон одоогийн мэдэгдэл нь хоорондоо зөрчилдөж байвал, уг зөрчилдсөн мэдэгдлийг гарган тухайн этгээд өөртэйгөө зөрчилдсөн болохыг харуулах боломжтой (§124).

Итгэл төрүүлэхүйц бус байдал (unconvincing evidence): Прокурорын нотолгоо дан/голчлон дам мэдүүлэгт тулгуурласан бөгөөд тухайн хэргийн ач холбогдолтой харьцуулахад итгэл төрүүлэхүйц бус гэж шүүх дүгнэвэл цагаатгах, эсхүл дахин шүүх хуралдаан товлоно (§125). Үүнд:

- яллагдагчийн эсрэг хэрэг нь бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн шүүхийн ажиллагаанд амаар өгсөн мэдүүлэг бус дам мэдүүлэгт үндэслэсэн бол;
- уг дам мэдүүлгээр өгөгдсөн нотлох баримт нь тухайн хэргийн хувьд ач холбогдолтой байдалтай харьцуулахад итгэл төрүүлэхүйц бус бол.

Хүлээн зөвшөөрөлт (confessions)**:** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагчийн хийсэн хүлээн зөвшөөрөлтийг хамт яллагдагчийн хэрэгт (өөрөөр хэлбэл, нэг хэрэгт хамт шүүгдэж буй этгээдийн хэрэгт) нотлох баримтаар ашиглаж болно. Гэхдээ зөвхөн тухайн асуудалд холбогдож буй хэмжээгээр ашиглана. Харин шахалт (oppression)[21], эсхүл тухайн байсан нөхцөлд хэнээс ч гарахуйц найдвартай бус болгох үйлдэл, хэллэгийн улмаас гарсан бол шүүх хүлээн авахгүй. Үүнийг эсрэг тал магадлалын тэнцвэр (Balance of probabilities)-ээр эс зөвшөөрсөн тохиолдолд л ашиглана (§128).

Мөн хуулийн 129 дүгээр зүйлд зааснаар хүн бус этгээд (жишээлбэл, төхөөрөмж, автомат систем)-ээр хийгдсэн, үнэн зөв байдал нь эцсийн дүндээ хүний (шууд болон

[21] Нотлох баримтын тухай хуулийн 126(7). Энэ зүйлд заасан “шахалт” (oppression) гэдэгт тамлах, хүнлэг бус, эсхүл доромжилсон байдалтай харьцах, хүч хэрэглэсэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх ойлголтыг багтаана.

шууд бус) өгсөн мэдээлэлд тулгуурлаж байгаа бол уг илэрхийллийг нотлох баримт болгон зөвшөөрөхгүй. Зөвхөн уг мэдээлэл үнэн зөв болохыг нь нотолсон тохиолдолд зөвшөөрнө.

4.5.Канад Улс

Шүүгч нь тухайн нотолгоо найдвартай бөгөөд зохистой гэж үзвэл, Канад Улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдөхгүй байсан ч шүүгч нотлох баримтаар хүлээн авч, уг нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргаж болно (38.06(3.1)

Бизнесийн бүртгэлийг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрөх: Тухайн асуудалтай холбоотой аман нотлох баримтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүлээн зөвшөөрөх боломжтой бол тухайн асуудалд холбоотой мэдээллийг агуулсан бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад хийсэн тэмдэглэлийг ашиглахыг зөвшөөрнө. Шүүх тэмдэглэлийг шалгаж, нотлох баримтыг сонсож болно (§30).

Санхүүгийн байгууллагад[22] хадгалагдаж буй аливаа дэвтэр, тэмдэглэлийн хуулбар, тэдгээрт бичигдсэн зүйлс, гүйлгээ, дансны талаарх мэдээллийг нотлох баримтаар хүлээн зөвшөөрнө (§29).

Цахим баримт бичгийг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрөхийг хүссэн этгээд тухайн цахим баримт бичгийг мөн болохыг нотлох үүрэгтэй.

4.6.Оросын Холбооны Улс

а) <u>Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуулийн 75 дугаар зүйлд зөвшөөрөгдөхгүй нотлох баримтыг зохицуулсан. Тус зүйлд зааснаар хуулийн шаардлагыг зөрчин олж авсан нотлох баримт нь зөвшөөрөгдөхгүй бөгөөд эрх зүйн хүчин төгөлдөр бус, яллах дүгнэлтэд ашиглагдах, эсхүл хэргийн нөхцөл байдлыг тогтоох үндэслэл болох боломжгүй (§75.1).

Зөвшөөрөгдөхгүй нотлох баримт: Дараах нотлох баримт нь зөвшөөрөгдөхгүй (§75.2):

- сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчийн оролцоогүйгээр өгсөн (өмгөөлөгчөөс татгалзсан тохиолдлыг хамруулна) ба шүүхэд баталгаажаагүй мэдүүлэг;
- хохирогч, гэрчийн таамаглал, цуу яриа, эх сурвалжаа тодорхойлох боломжгүй мэдүүлэг;
- өмгөөлөгчийн үйлчлүүлэгчийн хэрэгтэй холбоотойгоор түүний үйлдвэрлэлд буй эд зүйл, баримт бичиг, мэдээллийг хууль бусаар авсан тохиолдол;
- иргэдийн хөрөнгө, банкны дансыг сайн дурын мэдүүлгийн дагуу гаргасан “тусгай мэдүүлэг” болон түүнд хавсаргасан баримтуудыг хууль зөрчиж авсан тохиолдол;
- бусад хуулийн шаардлагыг зөрчин олж авсан нотлох баримт.

Нотлох баримтыг шалгах: Хуулийн 87 дугаар зүйлд зааснаар нотлох баримтыг шалгах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь тухайн баримтыг эрүүгийн хэрэгт байгаа бусад нотлох баримттай харьцуулан үзэх, эх сурвалжийг тогтоох,

[22] Нотлох баримтын тухай хуулийн 29(9). Санхүүгийн байгууллага гэж Канадын Банк, Канадын бизнесийн Хөгжлийн банк болон Канад Улсад өөрийн гишүүд болон олон нийтээс мөнгөн хадгаламж хүлээн авдаг аливаа байгуулагыг хэлнэ.

мөн шалгаж буй баримтыг батлах эсхүл няцаах бусад нотлох баримтыг цуглуулах замаар явуулна.

Нотлох баримтыг үнэлэх журам: Хуулийн 88 дугаар зүйлд зааснаар нотлох баримт бүрийг холбогдол, зөвшөөрөгдөх байдал, үнэн зөвийн үүднээс үнэлнэ. Харин хэрэгт цуглуулсан нотлох баримтыг нийлбэрээр нь авч үзэж, эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд хангалттай эсэхийг тогтооно (§87.1).

Шүүх, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч хуулийн 75.2-т заасан буюу дээр дурдсан нотлох баримтыг зөвшөөрөгдөхгүй гэж үзнэ (§87.2).

Түүнчлэн прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь сэжигтэн, яллагдагчийн хүсэлтээр эсхүл өөрийн санаачилгаар нотлох баримтыг зөвшөөрөгдөхгүй гэж хүлээн зөвшөөрч болно. Зөвшөөрөгдөхгүй гэж тооцсон нотлох баримтыг яллах дүгнэлт, яллах акт, эсхүл яллах тогтоолд хавсаргахгүй (§87.3).

Шүүх нотлох баримтыг зөвшөөрөгдөхгүй гэж талуудын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар, энэ хуулийн 234 (Урьдчилсан хэлэлцүүлэг явуулах журам) болон 235 (Нотлох баримтыг хасах хүсэлт)-д заасан журмын дагуу тогтоож болно..

б) <u>Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуульд нотлох баримтын зөвшөөрөгдөх нөхцөлийг (1) нотлох баримтын зөвшөөрөгдөх байдал, (2) нотлохоос чөлөөлөх болон (3) нотлох баримтыг үнэлэх гэсэн гурван үндсэн чиглэлээр тусгайлан зохицуулсан.

Нотлох баримтын зөвшөөрөгдөх байдал: Хуулийн дагуу зөвхөн тодорхой төрлийн нотлох хэрэгслээр баталгаажуулах ёстой хэргийн нөхцөл байдлыг өөр төрлийн нотлох баримтаар баталж үл болно (§60).

Нотлохоос чөлөөлөх үндэслэл: Хуульд дараах нөхцөл байдлыг шүүхэд нотлох шаардлагагүй гэж хуульчилсан (§61). Үүнд:

- шүүхийн зүгээс нийтэд мэдэгдэж байгаа гэж үзсэн нөхцөл байдлыг нотлох шаардлагагүй;
- өмнө нь шийдвэрлэгдсэн хэрэгт хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийн агуулгыг дахин нотлохгүй бөгөөд маргах боломжгүй. Энэ нь ижил талууд оролцож буй өөр хэрэгт болон хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэгдэнэ;
- хүчин төгөлдөр болсон Арбитрын шүүхийн шийдвэрийн хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлыг тухайн хэрэгт оролцсон талууд дахин нотлохгүй бөгөөд маргах эрхгүй;
- эрүүгийн хэрэгт шүүхийн хүчин төгөлдөр болсон яллах тогтоол болон бусад шийдвэр, захиргааны зөрчлийн хэрэгт шүүхийн шийдвэр нь тухайн үйлдэл болсон эсэх, мөн уг үйлдлийг тухайн этгээд хийсэн эсэхийг тогтоохтой холбоотой асуудлаар иргэний хэргийг шийдвэрлэх шүүхэд заавал биелэгдэх хүчинтэй;
- нотариатын ажиллагааны явцад тогтоогдсон нөхцөл байдлыг дахин нотлох шаардлагагүй. Харин баримтын жинхэнэ эсэхийг хуулийн дагуу няцаасан эсхүл нотариатын ажиллагаанд ноцтой зөрчил тогтоогдсон бол нотлох ажиллагаа шаардагдана.

Нотлох баримтыг үнэлэх журам: Хуульд шүүхийн нотлох баримтыг үнэлэхтэй холбоотой дараах үндсэн зарчмуудыг тогтоосон (ст. 67). Үүнд:

- шүүх нотлох баримтыг бүх талаас нь бүрэн, бодитой, шууд судалсны үндсэн дээр өөрийн дотоод итгэл үнэмшилд тулгуурлан үнэлнэ;
- аль ч нотлох баримт шүүхийн хувьд урьдчилан тогтоосон заавал хүчинтэй байр суурь эзлэхгүй;
- шүүх нотлох баримт бүрийг тусад нь авч үзэж, холбогдол, зөвшөөрөгдөх байдал, үнэн зөвийн үүднээс үнэлнэ. Мөн цугларсан баримтын нийлбэр нь хангалттай эсэх, харилцан уялдаа холбоог нь дүгнэнэ;
- шүүхийн шийдвэрт аль баримтыг үндэслэл болгон хүлээн авсан, аль баримтыг үгүйсгэсэн, мөн аль баримтад илүү ач холбогдол өгсөн үндэслэл, шалтгааныг заавал тусгана;
- шүүх тухайн бичиг баримт эрх бүхий байгууллагаас гарсан эсэх, эрх бүхий этгээдийн гарын үсэгтэй эсэх, шаардлагатай реквизитийг агуулсан эсэхийг бусад баримттай харьцуулан баталгаажуулна;
- шүүх хуулбарын агуулга эх хувьтайгаа тохирч байгаа эсэх, ямар техник хэрэглэн хуулбарласан, хуулбар хадгалалтын явцад өөрчлөгдөөгүй эсэхийг шалгана;
- хэрэв эх хувь алдагдсан, шүүхэд ирүүлээгүй, талуудын гаргасан хуулбаруудын агуулга хоорондоо зөрүүтэй бөгөөд бусад баримтаар эх хувь тогтоох боломжгүй бол зөвхөн хуулбар дээр тулгуурлан нөхцөл байдлыг нотлогдсон гэж үзэж үл болно.

4.7.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

а) <u>Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар дараах үндсэн нөхцөлүүд хангагдаагүй бол нотлох баримт гэж үзэхгүй. Үүнд:

1) эрүүдэн шүүх, албадах, бие махбодод хүч хэрэглэх, эм хэрэглэх, тамлах, төөрөгдүүлэх, гипноз зэрэг аргыг ашиглан олж авсан нотлох баримтыг хэрэглэхийг хориглоно (§136a). Ийм аргаар авсан мэдүүлгийг яллагдагч хүлээн зөвшөөрсөн байсан ч нотлох баримтаар ашиглаж үл болно;
2) шүүхийн зөвшөөрөл авсан байх шаардлагыг хангах шаардлагатай бөгөөд шүүх хэргийн нотолгооны хууль ёсны байдлыг хэргийн нөхцөл байдал/эрхийн зөрчил зэргийг харгалзан үнэлнэ. Тухайлбал, хуулийн 100a дугаар зүйлд заасан утас, цахим шуудан, мэдээллийн системээс таслан авах, нууцаар хянахад шүүхийн зөвшөөрөл авна. Мөн хуулийн 102 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн эсхүл, хамжигчийн хувиар оролцсон, туслалцаа үзүүлсэн, ял гүйцэтгэхэд саад учруулсан, хулгайлагдсан эд зүйлтэй харьцсан гэх үндэслэл бүхий этгээдийн бие, эд хөрөнгө, орон байранд нэгжлэг хийхийг зөвшөөрнө.

Хуулийн 100a.5-д зааснаар харилцаа холбоог хянах арга хэмжээ авахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- зөвхөн тухайн үеийн харилцаа холбоо, эсхүл шүүхийн шийдвэр гарснаас нийтийн сүлжээгээр дамжих шифрлэлгүйгээр хянах боломжтой агуулга, нөхцөл байдлыг хянаж, баримтжуулна.
- мэдээллийн технологийн системд зайлшгүй шаардлагатай өөрчлөлт л хийнэ.
- арга хэмжээ дуусмагц хийсэн өөрчлөлтийг техникийн боломжтой бол автоматаар буцаана.

б) <u>Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн зохицуулалт:</u>

Хуульд нотлох баримтын зөвшөөрөгдөх нөхцөлийг дараах байдлаар зохицуулсан байна. Цахим баримт бичиг (§371a): Цахим баримт бичгийг дараах тохиолдолд хүчинтэйд тооцно. Үүнд:

- Баталгаажсан цахим гарын үсэг бүхий баримт бичиг нь цаасан хэлбэрийн баримт бичигтэй адил хүчинтэйд тооцогдоно;
- “De-Mail” системээр илгээгдсэн мессеж нь илгээгчийг баталгаажуулсан нотолгоо болно;
- Төрийн байгууллага эсхүл итгэмжлэгдсэн этгээдээс гаргасан цахим хэлбэрийн баримт бичиг нь төрийн албан ёсны баримт бичгийн адил хүчин төгөлдөр байна.

Сөрөг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд баримт бичгийн жинхэнэ, эсхүл хуурамч эсэх, мөн 592[23] дугаар зүйлд дурьдсанаас бусад баримтын хувьд зөвхөн баримт бичиг болон талуудын үзлэгт хамрагдах хүсэлтийг нотлох баримт болгон хүлээн зөвшөөрнө (§595).

[23] 592 дугаар зүйл. Хүлээн зөвшөөрөгдөх байдал (Admissibility)
Бизнесийн харилцаанд ердийн байдлаар тоо, хэмжүүр, жин, үнэт цаасны гүйцэтгэлээр тодорхойлогддог тодорхой хэмжээний мөнгө төлсөн, эсхүл тодорхой хэмжээний эд хөрөнгийн гүйцэтгэлтэй холбоотой нэхэмжлэлийн хувьд, нэхэмжлэгч нь шаардлагатай бүх баримтыг бүрэн нотлох боломжтой тохиолдолд баримт бичгийн нотлох баримтад тулгуурласан хялбаршуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэж болно. Ипотекийн зээл, газрын барьцаа, газрын төлбөр, далайн хөлгийн барьцаанаас үүссэн нэхэмлэл нь мөн мөнгөн төлбөр шаардах нэхэмжлэл хамаарна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нотлох баримтын эрх зүйн зохицуулалт нь улс орон бүрийн эрх зүйн тогтолцоо, шүүх ажиллагааны зарчим, оролцогчдын эрх зүйн байр сууриас хамааран ялгаатай байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд уламжлалт хоёр загвар – яллах загвар (accusatorial model) болон эрэн сурвалжлах загвар (inquisitorial model) төлөвшсөн бөгөөд орчин үед эдгээрийн онцлогийг хослуулсан холимог загвар (mixed model) өргөн хэрэглэгдэх болжээ.

Яллах загвар нь хохирогчийн хувийн нэхэмжлэлд үндэслэсэн хэрэг үүсгэж нотолгоо гаргах бол эрэн сурвалжлах загвар нь хохирогч гомдол гаргасан эсэхээс үл хамааран мөрдөн шалгах байгууллагаас шалгаж, шүүгдэгчийн мэдүүлэгт голлон тулгуурладаг.

Холимог загвар нь энэ хоёр загварын онцлогийг хослуулж, мөрдөн байцаалт ба шүүх хуралдаан гэсэн хоёр үе шаттай. Гэмт хэрэг илэрсэн тохиолдолд хохирогч гомдол гаргаагүй байсан ч хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагааг заавал явуулдаг онцлогтой.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хууль тогтоомжийг авч үзвэл, нотлох баримтыг эрх зүйн тогтолцооны онцлогт нийцүүлэн бие даасан хууль, эсхүл процессын хуулиудаар зохицуулж байгааг дараах байдлаар харьцуулан үзэж болно.

Нотлох баримтын эрх зүйн зохицуулалт: Судалгаанд авагдсан улсуудыг туршлагаас харахад, Австрали, Канад, АНУ зэрэг Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнууд нотлох баримтын харилцааг бие даасан нотлох баримтын тухай хууль, дүрмээр нарийвчлан зохицуулж байна. Эдгээр нь нотлох баримтын төрөл, хүлээн зөвшөөрөгдөх нөхцөл, хэрэглэгдэх стандарт, шүүхийн үнэлгээний шалгуурыг нарийн тогтоосон байна. Харин ХБНГУ, БНСУ, ОХУ зэрэг Ром-Германы болон холимог тогтолцоотой орнууд ИБУИНХУ нотлох баримтыг эрүү болон иргэний процессын хуулиудад нэгтгэн зохицуулсан байна.

Нотлох баримтын төрөл: Судалгаанд хамрагдсан улсууд гэрчийн мэдүүлэг, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт зэрэг уламжлалт төрлийг хуульчилсан байна. Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудын хувьд, Австрали, АНУ, ИБУИНХУ-д дам мэдүүлэг болон зан чанарын нотолгоог бие даасан төрлөөр хуульчилсан бол Канад, ИБУИНХУ-д цахим нотлох баримт, дүрс бичлэгийг бие даасан төрлөөр авч үзсэн нь цахим нотолгооны хэрэглээг хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна.

Харин Ром-Германы эрх зүйн тогтолцоотой БНСУ, ХБНГУ-д эдгээр төрлийг хуульчлаагүй бөгөөд гэрчийн мэдүүлгийн үнэн зөвийг үнэлэх хүрээнд авч үздэг.

Хүснэгт 1. Нотлох баримтын төрөл (Харьцуулсан хүснэгт)

Австрали	Нотлох баримтын тухай хууль	гэрч баримт бичиг дам мэдүүлэг бусад
АНУ	Нотлох баримтын холбооны дүрэм	зан чанар дадал зуршил гэрч шинжээчийн мэдүүлэг, санал дам мэдүүлэг баримт бичиг

БНСУ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	үзлэг гэрч шинжээчийн нотолгоо
	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	гэрчийн мэдүүлэг шинжээчийн мэдүүлэг бичмэл нотлох баримт хяналт шалгалт бусад нотлох баримт
ИБУИНХУ	Эрүүгийн шударга ёсны тухай хууль	муу зан чанар дам мэдүүлэг баримт бичиг шинжээчийн нотолгоо дүрс бичлэг
	Иргэний нотлох баримтын тухай хууль	шинжээчийн дүгнэлт дам мэдүүлэг Ерөнхий эрх зүйн уламжлал баримт бичиг
Канад	Нотлох баримтын тухай хууль	гэрч баримт бичиг цахим нотлох баримт
ОХУ	Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль	сэжигтний мэдүүлэг яллагдагчийн мэдүүлэг хохирогчийн мэдүүлэг гэрчийн мэдүүлэг шинжээч болон мэргэжилтний дүгнэлт, мэдүүлэг биет нотлох баримт мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл бусад бичиг баримт
	Иргэний байцаан шийтгэх тухай хууль	талууд болон гуравдагч этгээдийн тайлбар гэрчийн мэдүүлэг бичиг баримт биет нотлох баримт дуу болон дүрсний бичлэг шинжээчийн дүгнэлт
ХБНГУ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	гэрч шинжээчийн тайлан мэргэжлийн дүгнэлт баримт бичиг, эд мөрийн баримт
	Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	гэрчийн мэдүүлэг шинжээчийн дүгнэлт баримт бичиг

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын хууль тогтоомжуудад тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

Нотлох баримт цуглуулах журам: Судалгаанд хамрагдсан улс орнууд нотлох баримт цуглуулах журмыг нотлох баримтын тухай хууль болон эрүү, иргэний процессын хуулиар зохицуулж байгаагаас хамаарч өөр өөр зохицуулалттай байна. Англи-саксоны эрх зүйн тогтолцоотой орнууд болох Австрали, Канад, АНУ, ИБУИНХУ-уудад тусгай хуулиар зохицуулж байна. Харин ХБНГУ, БНСУ болон ОХУ-д эрүү болон иргэний процессын хуулиар зохицуулдаг.

Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдал: Судалгаанд хамрагдсан улс орнуудад нотлох баримтын хүлээн зөвшөөрөх нөхцөл бүх улсад хамаарал, найдвартай байдал, хууль ёсны байдлын шалгуурт тулгуурладаг. Хууль бус нотолгооны хориг

Австрали, БНСУ, ОХУ, ХБНГУ-д илүү нарийн хуульчилсан бол АНУ, ИБУИНХУ-д шүүхийн үзэмжийн зарчим давамгайлдаг.

Австрали Улсад нотлох баримт нь хамааралтай байдлыг мрагаантай баримтын үнэн эсэхэд нөлөөлөх чадвараар тодорхойлох бөгөөд шүүх шударга бус байдал үүсгэх, талуудыг төөрөгдүүлэх, хууль бусаар олж авсан тохиолдолд нотлох баримтыг хасна. Канад Улсад нотолгооны найдвартай, зохистой эсэхийг шүүгчийн үзэмжээр тодорхойлдог. Бизнесийн бүртгэл, санхүүгийн болон цахим баримтыг найдвартай гэж үзвэл хүлээн зөвшөөрдөг. АНУ-д нотлох баримтын хамааралтай байдал нь тухайн баримт үйл баримтыг илүү магадлалтай болгож буй эсэхээс хамаарна. Хуулиар хязгаарласан баримтуудыг хүлээн зөвшөөрөхгүй. ИБУИНХУ-д нотлох баримтын найдвартай байдал алдагдсан, хууль бусаар өөрчлөгдсөн, эсхүл зохиомол бол хүлээн зөвшөөрөхгүй. Яллагдагчийн “муу зан чанар”-ыг нотлох нотолгоог зөвхөн хуульд заасан тодорхой нөхцөлд зөвшөөрөхөөр хуульчилсан. БНСУ-д эрүүгийн нотлох баримт хууль ёсны журам зөрчиж авсан, эрүүдэн шүүсэн, албадлага хэрэглэсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөхгүй. Мөн нэг мэдүүлэгт үндэслэн яллахыг хориглодог. ОХУ-ын эрүүгийн процессын хууль нь нотлох баримтыг цуглуулах, шалгах, үнэлэх зэрэг үйл явцад тулгуурлан хүлээн зөвшөөрөхгүй байхыг, харин иргэний процессын хууль нь цуглуулах, хадгалах, шинжлэх зэрэгт тулгуурлан хүлээн зөвшөөрөх, эсхүл хүлээн зөвшөөрөхгүй байхыг тус тус дэлгэрэнгүй зохицуулдаг. ХБНГУ-д эрүүдэн шүүх, хүч хэрэглэх, төөрөгдүүлэх зэрэг бие махбод, сэтгэл санааны дарамт үзүүлж олж авсан нотлох баримтыг хүлээн зөвшөөрөхгүй.

Дам мэдүүлгийн хэрэглээ судалгаанд хамрагдсан улсуудад зөвшөөрөгдөхгүй ч, зөвхөн тусгай нөхцөлд хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, Австрали, ИБУИНХУ, БНСУ-д дам мэдүүлгийг ердийн нөхцөлд хориглож, онцгой нөхцөлд зөвшөөрдөг.

Нотлох баримтыг үнэлэхдээ шүүх дотоод итгэл үнэмшил, нотолгооны үнэ цэнийг харгалзан эрх зүйн шударга ёсны үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлдэг.

Хүснэгт 2. Нотлох баримтын хүлээн зөвшөөрөгдөх байдал (Харьцуулсан хүснэгт)

Улс	Хамаарал ба холбоо	Хууль ёсны байдал	Хязгаарлалт ба онцлог	Нотлох стандарт
Австрали	§56–58-д хамаарал, жинхэнэ байдал, холбоосыг нарийвчлан зохицуулсан.	§138-д хууль бус, зохисгүй байдлаар авсан нотолгоог шүүхийн үзэмжээр хасна.	Санал бодлын нотолгоо, зан төлөвийн нотолгоонд хязгаар тогтоосон.	Иргэний хэрэгт “магадлалуудын тэнцвэр”, Эрүүгийн хэрэгт “эргэлзээгүйгээр” нотлогдсон байх зарчмыг баримтална.
АНУ	Хамааралтай нотлох баримтыг хүлээн зөвшөөрнө. Хамааралгүй бол хүлээн зөвшөөрөхгүй.	Үндсэн хууль, холбооны хууль, шүүхийн дүрэмд нийцсэн байх ёстой.	Эвлэрэл, бэлгийн шинжтэй хэрэг, эмнэлгийн зардлын нотолгоо хязгаарлагдана.	Нотлох баримтыг хасах эсэхийг шүүх үзэмжээр шийдвэрлэнэ.
БНСУ	Нотолгоо зөвхөн хууль ёсны, сайн дурын мэдүүлэг байх ёстой.	Эрүүдэн шүүх, албадлага, хууль бус ажиллагаагаар олсон баримт хүчингүй.	Нэг мэдүүлэгт тулгуурлан шийдвэр гаргахыг хориглоно.	Эрүүгийн хэрэгт “зохистой эргэлзээ үлдэхгүй”; иргэний хэрэгт дотоод итгэл үнэмшилээр шийдвэрлэнэ.

ИБУИНХУ	Хамаарал, найдвартай байдалд тулгуурлана.	Хууль бус, гадны нөлөөтэй нотолгоо хасна.	Муу зан чанар, дам мэдүүлэг, итгэл төрүүлэхүйц бус нотолгоог хязгаарлана.	Нотлох баримтыг хасах эсэхийг шүүх үзэмжээр шийдвэрлэнэ.
Канад	Шүүгч найдвартай, зохистой гэж үзвэл хүлээн зөвшөөрч болно.	Тус улсын хуулиар зөвшөөрөөгүй байсан ч шүүх зохистой гэж үзвэл ашиглаж болно.	Бизнесийн болон цахим баримтыг өргөн хүрээнд зөвшөөрдөг.	Шүүгчийн дотоод итгэл үнэмшилд тулгуурлана.
ОХУ	Хуулийн §75-88-д нарийн журам тогтоосон.	Хууль зөрчиж авсан аливаа баримт хүчингүй.	Өмгөөлөгчгүй мэдүүлэг, цуу яриа, хууль бус авсан баримт хасагдана.	Шүүх “дотоод итгэл үнэмшил” ба “хууль ёсны байдлыг” хамтатган үнэлнэ.
Герман	Эрүүдэн шүүх, төөрөгдүүлэх зэргээр авсан нотолгоог хориглоно.	Шүүхийн зөвшөөрөл шаардлагатай (нэгжлэг, тагнах, мэдээлэл хураах)	Харилцаа холбоо хянах, мэдээллийн системд хөндлөнгөөс оролцох хатуу хязгаарлалтай.	Нотолгооны хууль ёсны байдлыг шүүх өөрөө үнэлнэ.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын хууль тогтоомжуудад тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

НОМ ЗҮЙ

- Нээлттэй нийгэм форум, Нотолгооны өнөөгийн практик, арга зүй, техник хэрэгсэл, анхаарах асуудал: судалгааны тайлан, 2021 он
- Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын ЭБШ эрх зүй (Ерөнхий анги), УБ, 2006 он
- Австрали: Evidence Act (1995) https://www.legislation.gov.au/C2004A04858/2012-07-01/text
- Канад: Canada Evidence act 1985/2024 https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-5/page-1.html
- Англи: Criminal Justice Act, (2003) https://www.legislation.gov.uk/ukpga/2003/44/contents
- Англи, Civil Evidence Act (1995) https://www.legislation.gov.uk/ukpga/1995/38/contents https://www.legislation.gov.uk/ukpga/1972/30
- АНУ: Federal Rules of Evidence (1975) https://www.uscourts.gov/sites/default/files/2025-02/federal-rules-of-evidence-dec-1-2024_0.pdf
- Герман: German Code of Criminal Procedure (1987/2024) https://www.gesetze-im-internet.de/englisch_stpo/englisch_stpo.html
- Герман: Code of Civil Procedure (2005/2021) https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html
- БНСУ: Criminal procedure act (1954/2024) https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535
- БНСУ: Act on the Use of Electronic Documents in Summary Proceedings (2020) https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=56947&key=9&type=sogan
- БНСУ: Civil procedure act (1960/2024), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=38478&lang=ENG
- ОХУ: Гражданский процессуальный кодекс (2002) [2025]. Хандах: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_39570/